



Монголын Эмэгтэйчүүдийн Сан

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД
ЖЕНДЭРИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ ХИЙХ

ГАРЫН АВЛАГА

Байгаль орчин, эмэгтэйчүүдийн эрхийн
хамгаалагчдад зориулав.

Улаанбаатар хот
2020 он



Энэхүү гарын авлагыг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн Нидерланд улсын Мама кейш сан (Mama cash), GAGGA (Жендэр болон ногоон үйл ажиллагааны төлөө дэлхийн альянс) эвсэлд талархал илэрхийлье. Гарын авлагын утга санаа нь санхүүжүүлэгч байгууллагын байр суурийг илтгэхгүй болно.

АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт	4
Нэр томъёоны тайлбар	5
Гарын авлагын тухай	8
НЭГ. Уул уурхайн үйл ажиллагаанд жендэрийн үр нөлөөний үнэлгээг яагаад хийх ёстой вэ?	10
Зорилго, ач холбогдол.....	10
Зарчим	11
Намрах хүрээ.....	12
ХОЁР. Уул уурхайн үндсэн ойлголтууд	14
Уул уурхайн олборлолт хэрхэн явагддаг вэ? Ямар үе шатуудтай байдаг вэ?	14
Олборлолтын үе шатууд	14
Уул уурхайн олборлолтын үед ямар химийн бодис ашигладаг вэ?	15
Уул уурхайн байгаль орчин, хүн амын эрүүл мэнд, нийгэмд үзүүлэх үр нөлөө	19
Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл.....	19
Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл.....	20
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл.....	21
Жендэртэй холбоотой нөлөөлөл	22
Уул уурхайн байгаль орчин, эрүүл мэнд, нийгэмд үзүүлэх үр нөлөө.....	19
ГУРАВ. Уул уурхайн үйл ажиллагаанд жендэрийн үр нөлөөний үнэлгээ хийх нь	24
ЖҮНҮ хийх хөтөлбөр боловсруулах	24
ЖҮНҮ хийх мэдээлэл цуглуулах арга зүйгээ тодорхойлж, мэдээлэл цуглуулах	27
Дүгнэлт	63

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж Ахуйн Нэгж
АМГТГ	Ашигт Малтмал Газрын Тосны Газар
АМТХ	Ашигт Малтмалын Тухай Хууль
БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн Хурал
БООАЖЯ	Байгаль Орчин, Аялал, Жуулчлалын Яам
БОМТ	Байгаль Орчны Менежментийн Төлөвлөгөө
БОННУ	Байгаль Орчин, Нийгмийн Нөлөөллийн Үнэлгээ
БОНУ	Байгаль Орчин, Нийгмийн Үнэлгээ
БОЯ	Байгаль Орчны Яам
ЖҮНҮ	Жендэрийн Үр Нөлөөний Үнэлгээ
ЗГ	Засгийн Газар
ЗЕХ	Захиргааны Ерөнхий Хууль
ИНХ	Иргэдийн Нийтийн Хурал
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МОНЭС	Монголын Эмэгтэйчүүдийн Сан
ОХШХ	Орчны Хяналт Шинжилгээний Хөтөлбөр
ТББ	Төрийн Бус Байгууллага
ЭТББ	Эмэгтэйчүүдийн Төрийн Бус Байгууллага
WAMA	Women in Action Mining in Asia (Уул уурхайн эсрэг Азийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн)

НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

Ашигт малтмал ашиглах гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг¹;

Ашигт малтмал гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг²;

Ашигт малтмал хайх гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг³;

Аюултай бохирдуулах бодис гэж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад орсон бодисыг⁴;

Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг⁵ хэлнэ.

Бохирдуулах бодис гэж хаягдал усанд агуулагдаж, хүрээлэн байгаа орчныг бохирдуулж байгаа бодис, тэдгээрийн хольцыг⁶;

Жендэрийн эрх тэгш байдал гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг⁷;

Мэргэшсэн мэргэжилтэн, шинжээч гэж үндэсний болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн, геологи, уул уурхайн салбарын төрийн бус байгууллагаас эрх олгогдсон иргэнийг⁸.

¹ Ашигт малтмалын тухай хууль, 4-р Зүйл (2006)

² Ашигт малтмалын тухай хууль, 4-р Зүйл (2006)

³ Ашигт малтмалын тухай хууль, 4-р Зүйл (2006)

⁴ Усны тухай хууль, 3-р Зүйл (2012)

⁵ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)

⁶ Усны тухай хууль, 3-р Зүйл (2012)

⁷ Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, 4-р Зүйл, (2011)

⁸ Ашигт малтмалын тухай хууль, 4-р Зүйл (2006)

Онцгой болон энгийн хамгаалалтын бүс гэдэгт усны сан бүхий газар, усны эх үүсвэр, рашааны ордыг хомсдох, бохирдохоос хамгаалах зорилгоор тогтоосон зурвас газрыг⁹;

Усны бохирдол гэж хүний шууд ба шууд бус үйл ажиллагааны улмаас байгалийн усны найрлага өөрчлөгдөж, усны чанар доройтохыг¹⁰;

Усны нөөцийн хомсдол гэж усны нөөц багасах, усны чанар, байгалийн үнэ цэнэ, өгөөж доройтохыг¹¹;

Хамтын ажиллагааны гэрээ гэж уул уурхайн компани, нутгийн өөрөө удирдах байгууллага /иргэдийн төлөөлөл/, нутгийн захиргааны байгууллагын хооронд байгуулсан гэрээ. Ашигт малтмалын тухай хуулийн 42.1-т зааснаар хайгуулын болон ашигт малтмалын лиценз эзэмшигч нь “орон нутгийн захиргаатай хамтран ажиллаж байгаль орчныг хамгаалах, уурхай байгуулах, уурхай байгуулахтай холбоотой дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээ байгуулж ажиллана” гэсэн байдаг.

Хаягдал гэж цаашид боловсруулахад эдийн засгийн ач холбогдолгүй ордны боловсруулагдсан (угаагдсан) хүдрийн хэсгийг¹² хэлдэг.

Хуримтлагдсан нөлөө – өнгөрсөн, одоо, мөн ойрын ирээдүйд таамаглаж болох үйл ажиллагаануудын тус бүрийнх нь нөлөөнүүд нийлж байгаль орчинд үзүүлэх нөлөө¹³

Хүний эрх¹⁴ гэдэг нь амьд явах, амьдрахад шаардлагатай хоол хүнс, унд, хувцас хунар, орон гэртэй байх гэх мэт наад захын хэрэгцээгээ хангах боломж, түүнийг эдлэх баталгааг хэлдэг.

Хүний эрхийн хамгаалагч гэж хүний эрхийг хамгаалахын төлөө тэмцэж буй бүх л иргэний нийгмийн байгууллага болон хувь хүнийг хэлнэ.

Эмэгтэйчүүдийн эрх гэдэг нь эмэгтэйчүүд эрэгтэйчүүдийн нэгэн адил хуулийн болоод нийгмийн ижил байр суурьтай байж, адилхан эрх эдлэхийг хэлнэ¹⁵.

⁹ Усны тухай хууль, 3-р Зүйл (2012)

¹⁰ Усны тухай хууль, 3-р Зүйл (2012)

¹¹ Усны тухай хууль, 3-р Зүйл (2012)

¹² Иргэний Шийдэл Бодлогын Судалгааны Хүрээлэнгээс Австралийн Квинсландын Их Сургуулийн Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэн, “Хариуцлагатай уул уурхай сургалтын гарын авлага”, 91-р тал (2016)

¹³ Иргэний Шийдэл Бодлогын Судалгааны Хүрээлэнгээс Австралийн Квинсландын Их Сургуулийн Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэн, “Хариуцлагатай уул уурхай сургалтын гарын авлага”, 91-р тал (2016)

¹⁴ МОНЭС & Хил Хязгааргүй Алхам ТББ, “Уул уурхай ба Иргэдийн оролцоо” гарын авлага, 49-р тал (2020)

¹⁵ Оксфордын тайлбар толь бичиг

Жендэрийн үр нөлөөний үнэлгээ гэж уул уурхайн сөрөг нөлөөлөл эмэгтэй, эрэгтэй хүмүүст хүйснээс хамаарч яаж өөрөөр тусаж байгааг тогтоох хэрэгсэл юм¹⁶.

Байгаль орчны менежментийн хөтөлбөр гэж Сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ (агаарын чанар, гадаргын ба газрын доорх усны нөөц, хөрсөн бүрхэвч, газрын хэвлий, ургамлан нөмрөг, амьтны аймгийг хамгаалах, хуримтлагдах нөлөөллийн үнэлгээгээр тогтоогдсон арга хэмжээ болон тухайн орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн арга хэмжээг тусган), нөхөн сэргээх арга хэмжээ (техникийн болон биологийн нөхөн сэргээлт), биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ, түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээ, химийн хортой болон аюултай бодисын эрсдэлийг бууруулах арга хэмжээ, хог, хаягдлын менежментийн арга хэмжээ, орон нутгийн захиргаа, аймаг нийслэлийн байгаль орчны газар, мэргэжлийн хяналтын байгууллага, ажлын хэсгийн дүгнэлт, шаардлагаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ, нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах үйл ажиллагаа, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэлнэ¹⁷.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр гэж төслийн нөлөөлөлд өртөж буй байгаль орчны дор дурдсан бүрдэл хэсгүүдийг заавал тусгаж, бүрдэл хэсэг тус бүрээр хяналт шинжилгээ хийх цэгийн байршил, хэмжилт, дээжлэлт авах үзүүлэлт, тоо, хугацаа, давтамж, зарцуулах зардал, хариуцан гүйцэтгэх этгээд, баримтлах стандарт, аргачлалыг нарийвчлан тусгана. Үүнд: газрын гадарга, хэвлий, агаарын чанар, дуу шуугиан, гадаргын ба газрын доорх ус, хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг, амьтны аймаг, цацрагийн түвшин (цацраг идэвхт ашигт малтмал хайх, олборлох төсөлд), хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалалт, зарцуулалт, уурхайн хаягдлын далангийн аюулгүй байдал, нөхөн сэргээх арга хэмжээний үр дүн, тухайн уурхайн онцлогтой холбогдсон бусад барилга байгууламж орно¹⁸.

¹⁶ WAMA, "Resource guide for monitoring extractives" handbook (2019)

¹⁷ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт: БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

¹⁸ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт: БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ

ГАРЫН АВЛАГЫН ТУХАЙ

Энэхүү гарын авлага эрдэс баялгийн хайгуул, олборлолтын болон боловсруулах үйлдвэрийн үйл ажиллагаа эхлүүлэхээр зэхэж байгаа, үйл ажиллагаа нь эхэлчихсэн байгаа, эсвэл олборлох үйл ажиллагаа нь дуусч хаагдаж байгаа болон орхигдсон уул уурхайн бүс нутагт амьдарч байгаа нутгийн эмэгтэйчүүд түүний гэр бүлийнхэнд үзүүлж буй уул уурхайн сөрөг нөлөөллийг үнэлж хэмжих, цаашид үүсэх эрсдэлийг урьдчилан тодорхойлоход туслах хөтөч болно гэж найдаж байна.

Байгаль орчин, эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалагч гэдэг нь байгаль орчин болоод хүний эрх тэр дундаа эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалахын төлөө тэмцэж буй бүх л иргэний нийгмийн байгууллага болон хувь хүнийг хэлнэ.

Энэхүү гарын авлагаар та бүхэнд дараах мэдлэг ойлголт, ур чадварыг олгох зорилготой.

Үүнд:

- Уул уурхайн олборлолтын талаарх үндсэн ойлголт
- Уул уурхайн олборлолтын үед ашиглагддаг химийн хортой бодисын талаарх ойлголт
- Уул уурхайн үйл ажиллагаанаас нөлөөллийн бүсийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, амьжиргаанд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх ойлголтууд
- Уул уурхайн сөрөг нөлөөлөл эмэгтэйчүүдэд хэрхэн ялгаатай тусдаг болох нь
- ЖҮНҮ-г нутгийн иргэд, хүний эрхийн хамгаалагчид, ТББ-ууд хэрхэн ашиглаж уул уурхайн сөрөг нөлөөлөл нь эмэгтэй, эрэгтэй хүмүүст хүйсээс хамаарч хувь хүн түүний гэр бүлд ялгаатай тусаж байгааг тогтоох, баримтжуулах
- Орон нутгийн эмэгтэйчүүд өөрийн болон гэр бүл, нутгийн хамт олныхоо эрх, эрх чөлөөг уул уурхайгаас үүдэлтэй сөрөг нөлөөллөөс хуулийн хүрээнд хамгаалах боломжууд
- Уул уурхайгаас үүдэлтэй эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийг хэрхэн баримтжуулах, цуглуулсан баримт дээрээ үндэслэн өөрсдийн зөрчигдсөн эрхийг сэргээх, хамгаалах, урьдчилан сэргийлэх боломжууд гэсэн цогц иж бүрэн мэдлэг, ур чадвар олгодог олон улсад туршигдсан аргачлалыг түгээх явдал юм.



БҮЛЭГ 1.

Уул уурхайн үйл
ажиллагаанд Жендэрийн
Үр Нөлөөний Үнэлгээг
яагаад хийх ёстой вэ?

01

Уул уурхайн үйл ажиллагаанд Жендэрийн Үр Нөлөөний Үнэлгээг яагаад хийх ёстой вэ?

Зорилго, ач холбогдол:

Манай улсад уул уурхайн бизнес эрчимтэй хөгжиж байгаатай холбогдуулан уул уурхайн олборлолт явуулж буй бүс нутагт тухайн орон нутгийн иргэд бэлчээрийн болон амьдрах газар нутгаа булаалган хөөгдөх, өвөг дээдсийн үеэс сүсэглэн тахиж ирсэн нийгэм, соёлын чухал ач холбогдолтой газруудад зорчих эрхээ хязгаарлуулах, устгуулах, эрүүл мэнд амь насаараа хохирох, байгаль орчны бохирдлоос үүдэлтэй орлого буурах, уурхайн компани болон зарим тохиолдолд Засгийн Газар болон төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс албан болон албан бусаар дарамт шахалт үзүүлэх зэрэг сөрөг нөлөөллүүд нийтлэг гарч байна.

Ялангуяа дээрх уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй сөрөг нөлөөлөл нь тухайн орон нутагт амьдарч буй эмэгтэйчүүдэд илүү хүндээр тусч, тэдний гэр бүлийн гишүүдийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх, малаас олдог орлогоо алдаж эдийн засгийн хохирол амсах, хүнсний аюулгүй байдал алдагдах, хүртээмж багасах, эрүүл мэндээрээ хохирох, гэр бүлийн гишүүд салангид амьдрахад хүрэх, хүчирхийлэлд өртөх гэх мэт тэдний амьдралын чанар, нөхцөл байдлыг улам эмзэг болгож байна.

Тиймээс энэ гарын авлага нь орон нутгийн малчин эмэгтэйчүүд болон эмэгтэйчүүдийн эрхийн хамгаалагчдад уул уурхайн олборлолт хэрхэн явагддаг талаар үндсэн ойлголтыг өгөх замаар түүнтэй холбоотойгоор эмэгтэйчүүдийн ямар эрхүүд шууд болон шууд бусаар хэрхэн зөрчигдөж байгааг ЖҮНҮ-ний тусламжтайгаар олж тогтоон баримтжуулж, хариу арга хэмжээ авах үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд нь туслах ач холбогдолтой юм.

Нэмж хэлэхэд МУ-д уул уурхайгаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг л зөвхөн үнэлж ирсэн. Гэтэл уул уурхайн үйл ажиллагааны сөрөг нөлөөлөл нь тухайн бүс нутагт амьдарч буй нутгийн иргэн, тэдний гэр бүлд ялгаатай нөлөөлөл үзүүлдэг. Зарим иргэд нь ажлын байраар хангагдаж, зарим нь бүтээгдэхүүн ханган нийлүүлж байгаа бол богино хугацаанд гарч буй эерэг нөлөөлөл гэж хэлж болно. Харин охид, эмэгтэйчүүдэд, тэдний нас болон гэрлэлтийн байдлаас шалтгаалан тусах нөлөөлөл нь

ялгаатай байдаг. Иймд 2012 онд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7-р зүйлийн 7.7 дахь хэсэгт “Нөлөөллийн үнэлгээний журам, аргачлалыг Засгийн газар батлах бөгөөд уг журам, аргачлалд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээтэй холбоотой асуудал, үнэлгээний шинжилгээ, хянан магадлагаа болон мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаа, нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээний талаарх зохицуулалтыг тусгана” гэж хуульчилсан. Харамсалтай нь тэр цагаас хойш бараг 10 жил болоход манай улсын Засгийн Газар нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийг үнэлэх аргачлал, журам боловсруулж батлаагүй хэвээр байна.

Манай улсад хэрэгжиж буй эрдэс баялгийн салбарын төслүүдэд “нийгэм, эрүүл мэндийн нөлөөллийн үнэлгээ” хийхгүй байгаа энэ нөхцөлд эмэгтэйчүүдийн эрхийн болон байгаль орчны шударга ёсны төлөө ажилладаг хүний эрхийн хамгаалагчид ЖҮНҮ-ний энэхүү аргачлалыг ашиглаж иргэдийн хүний эрх, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь баримт нотолгоонд үндэслэн сэргээлгэх нөлөөллийн ажил хийхэд нь шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох хэрэгсэл нь энэхүү гарын авлага байх болно гэдэгт итгэлтэй байна.

Зарчим:

Уур уурхайн олборлолтоос үүдэлтэй сөрөг нөлөөг ЖҮНҮ-ний аргачлалаар үнэлгээ хийхдээ дараах суурь зарчмыг/ концепцыг баримталбал зохистой. Үүнд:

- ЖҮНҮ аргачлалаар үнэлгээ хийхдээ оролцоог хангах буюу тухайн олборлолтын бүс нутагт байнга болон түр оршин сууж буй иргэд, эмэгтэйчүүдийн бодит оролцоотойгоор гүйцэтгэх, шийдвэр гаргалтад бодитой оролцуулах;
- Дэлхий нийтийн Тогтвортой хөгжлийн зорилтуудын “Хэнийг ч ардаа орхихгүй хөгжилд хүрэх” уриалгыг үндсэн үзэл баримтлал, үзэл санаагаа болгох
- Аливаа уул уурхайн хайгуул, олборлолт нь нэг ч хувь хүн, гэр бүлийн эрхийг хөндөж, амьжиргааг дордуулж болохгүй бөгөөд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд хүний эрхийг сэргээн хамгаалах бүхий л хариу арга хэмжээг авахыг эрмэлзэх үүрэгтэйг байнга санах;
- Ялгаварлан гадуурхахгүй байх – Хүнийг нас, хүйс, үндэс угсаа, ажил мэргэжил, шашин шүтлэг, хөрөнгө чинээ, нийгмийн гарал байдал, хөгжлийн бэрхшээл, үндэсний цөөнх гэх зэргээс үл харгалзан хүний эрх, эрхэм чанарыг хүндэтгэх;

Хамрах хүрээ:

Уг ЖҮНҮ /Жендэрийн үр нөлөөний үнэлгээ/-г хийхдээ тухайн олборлолт явуулж буй орон нутагт үзүүлж буй шууд нөлөөллийн бүсээс гадна дам нөлөөнд өртөх магадлалтай бүс нутгуудад хийхийг зөвлөж байна. Манай орны хувьд уул уурхайн олборлолт явуулж буй газраас дунджаар 0-50 км хүртэлх газрыг нөлөөллийн бүс¹⁹ хэмээн авч үзсэн туршлага нийтлэг байдаг ч, дам нөлөө хаа хүрч байгаа хүртэлх бүс нутгийг хамарч хийх шаардлагатай. Түүнчлэн, уул уурхайн төсөл бүр онцлогтой бөгөөд хаана ямар бүсэд, ямар ордыг, ямар технологиор олборлож байгаа нь нөлөөллийн бүсийг тогтооход нөлөөлнө. Мөн уул уурхайн төсөл нь цогц арга хэмжээ байдаг. Өөрөөр хэлбэл хайгуул- олборлолт- бүтээн байгуулалт- тээвэрлэлт- зах зээлд хүргэх тээвэр- ажилчдын суурьшлын бүс гэх мэт өргөн хүрээний цогцолбор төслийн нөлөөллийг хатуу тэдэн км гэж нэгдсэн тоо, радиусаар хязгаарлах боломжгүй байдаг.



¹⁹ https://www.ot.mn/media/ot/content/esia-audits/OT_ESIA_Audit_report_Nov_2014_MN.pdf



БҮЛЭГ 2.

Уул уурхайн үндсэн
ойлголтууд

02

Уул уурхайн үндсэн ойлголтууд



2.1 УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ ХЭРХЭН ЯВАГДДАГ ВЭ?

ЯМАР ҮЕ ШАТУУД БАЙДАГ ВЭ?

Уул уурхай гэж юу вэ?

Уул уурхайн төсөл гэдэг нь газрын хэвлийгээс ашигт малтмал олборлохыг хэлнэ. Ашигт малтмалд зэс, алт, мөнгө, никел, хромит, хөнгөн цагаан, нүүрс зэрэг олон төрлийн баяжмал багтана. Ашигт малтмалууд нь хүдэрт агуулагддаг бөгөөд хүдэр нь эрдэс баялаг агуулсан чулуулгийн биет болон тунамал ордуудыг хэлнэ.

Уурхайн үйл ажиллагааны үндсэн үе шатуудтай танилцсанаар байгаль орчин, хүний эрхийг хамгаалагч эмэгтэйчүүд нь уурхайн үйл ажиллагаа хэрхэн явагддагийг мэдэж авч, үүнд хяналт тавихад ойр дөхөм болно. Жишээлбэл, хайгуулын ажил эхэлсэн нь зам харгуй баригдаж эхлэх, уурхайн бүсийг тойруулж хашаа баригдахыг илтгэж болно. Уурхайн нээлт болон олборлолт нь ойр хавийн газар шороонд том хэмжээний өөрчлөлтүүдийг оруулна. Хэрэв хаягдлын далан баригдвал голын хэвийн урсгалд саад болох болно. Ингээд эцсийн үе шат болох уурхайг хаах үе шат эхэлдэг бөгөөд үүнд байгаль орчны нөхөн сэргээлт заавал тусгагдсан байх ёстой. Үүнийг хэрэгжүүлэхийг нутгийн иргэд тухайн компаниас шаардах эрхтэй.

Олборлолтын үе шатууд:

1. Эрэл хайгуул:

Хайгуул гэдэг нь ашигт малтмал хайж, олдсон газарт олборлолт хийхэд эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх процессыг хэлнэ. Мөн үүнд ашигт малтмалын нөөцийн хэмжээ, ордын байршил зэргийн талаар мэдээлэл цуглуулах багтана.

2. Уурхайн бүтээн байгуулалт

Уурхайн бүтээн байгуулалт гэдэг нь ашигт малтмалд хүрэхийн тулд малталт, агааржуулалт хийх, эрчим хүч холбох, уурхайчдын орц гарцыг гаргах, тэдний хангамж болон тоног төхөөрөмжийг байршуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөж, шаардлагатай барилга байгууламжийг барихыг хэлнэ.

3. Олборлолт

Олборлолт гэдэг нь газрын гүнээс ашигт малтмал агуулж буй хүдрийг гаргаж авахыг хэлнэ.

4. Боловсруулалт

Боловсруулалт гэдэг нь гүнээс гаргаж авсан хүдрээс ашигт малтмалыг салгаж, бусад хэрэггүй хог шороог ялгахыг хэлнэ. Үүнд баяжуулах болон цэвэршүүлэх процесс орох бөгөөд боловсруулалтыг ихэвчлэн уурхайн ойр орчинд хийдэг. Энэ шатанд ихэвчлэн химийн бодис ашиглагддаг.

5. Хаалтын үе шат

Хаалтын үе шат нь уурхайн үйл ажиллагаа дуусах үеийг хэлдэг бөгөөд үүнд уурхайг буулгах, задлах, аюулгүй байдал хангах үүднээс бэхэлгээ тогтоох болоод нөхөн сэргээлтийн ажлууд багтана²⁰. Өөрөөр хэлбэл, олборлолт явагдсан газрыг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгож хүлээлгэн өгөхийг хэлнэ.



2.2 УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТЫН ҮЕД ЯМАР ХИМИЙН БОДИС АШИГЛАДАГ ВЭ?

Уул уурхайн олборлолт явуулж, эрдэс баялгийг ялгаж авах үед олон төрлийн химийн бодис ашигладаг бөгөөд тэдгээр нь байгаль орчныг ихээр бохирдуулж, улмаар уурхайд ажиллаж буй ажилчид болон уул уурхайн ойр орчимд амьдарч буй олон нийтийн эрүүл мэндэд хор хохирол учруулдаг. Тэдгээрээс эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлдэг зарим химийн бодисыг танилцуулбал:

1. Цианит - алтыг хүдрээс ялгаж авахад хэрэглэгддэг нилээд үр дүнтэй, бас үнийн хувьд хямд химийн бодис юм. Гэвч энэ нь хийн болон хатуу төлөвийн аль ч бай, эсвэл ил задгай байхдаа ч хордуулах чанараа алддаггүй химийн хорт бодис юм. Маш бага хэмжээтэй цианит гэхэд л удаан хугацааны туршид хүний эрүүл мэндэд бамбай бурчирхай, амьсгалын замын хүндрэлүүд, хоолойн өвчин, хамар бөглөрөх, хамраас цус гарах, цустай цэр гарах зэрэг хортой нөлөөг үзүүлж байдаг.

2. Хүнд металлууд – уул уурхайн олборлолтын үе шатанд хүн, малын эрүүл мэндэд ноцтой хор хохирол учруулахуйц химийн бодис түүний хэрэглээнээс гарсан химийн аюултай хог хаягдал, агаарт гарч урвалд орсон хүнд металлуудыг маш ихээр бий болгодог. Үүнд:

²⁰ Эх сурвалж: Уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, байгаль орчин хүний эрхийг хамгаалах хүсэл эрмэлзэлтэй эмэгтэйчүүдэд зориулсан гарын авлага, Уул уурхайн үйл ажиллагаанд дахь Азийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, 2020

а. Мөнгөн ус – нь органик болон байгалийн гэсэн хоёр төрөлтэй байдаг. Алтыг хайлуулах үйл явцын үед байгалийн мөнгөн ус хортой хэмжээтэйгээр ялгардаг. Байгалийн мөнгөн ус нь маш их уурших чанартай бөгөөд тасалгааны температурт шингэн төлөвөөс хийн төлөвт шилжин ууршдаг. Уурхайн олборлолт хийж буй газарт байгалийн мөнгөн ус нь хортой хаягдал материалаас ялгарч болно. Ийм газарт мөнгөн усны хэмжээ нь ДЭМБ-аас гаргасан аюулгүйн хэмжээний зөвлөмжөөс хэд дахин их ялгарсан байдаг. Мөнгөн ус нь мэдрэлийн тогтолцоо, бөөр болон дархлааны тогтолцоонд сөргөөр нөлөөлдөг. Мөнгөн ус хэдий чиний их хэмжээгээр, удаан хугацаанд ялгарна төдий чинээ хүний эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлдэг. Урт хугацаанд мөнгөн усанд хордсоноор хүний аманд нь давирхай амтагдах, гэрэлд мэдрэг болох, генийн өөрчлөлт явагдах, бөөр гэмтэх, чичрэх, ядарч сульдах, нойр муудах, хоолны дуршлаа алдах, бүрэг ичимхий болох, жин хасах, ямар нэг юмнаас айдаг болох, стрессдэх, сандрах, уур уцаартай болох, ой санамжтай холбоотой ямар нэг асуудалтай болох зэрэг эрүүл мэндийн хортой нөлөө гарч байдаг. Хэдийгээр Монгол улс 1982 онд алтны уурхайд мөнгөн ус ашиглахыг хориглосон ч гар аргаар алт олборлогчид болон бичил уурхайнууд одоог хүртэл мөнгөн усыг хууль бусаар гэрийн нөхцөлд ашигласаар байна. Энэ нь эмэгтэйчүүд мөнгөн усыг ашиглан алтыг ялгаж авах үйл явцад хамгийн их оролцдог учир тэд илүү ихээр хорддог байна.

б. Цайр – бол алтыг олборлох үйл явцад ашигладаг. Хэдийгээр цайр нь байгаль дээр байдаг, мөн хүний биед тодорхой хэмжээгээр агуулагдаж байдаг ч хэмжээнээс хэтэрсэн цайр нь хортой нөлөөтэй байдаг. Цайранд хордох үед зүрхний хэм өсч, дотор муухайрах, толгой эргэх, толгой өвдөх, хамрын болон уушгины хөндийн хавдраар өвчлөх, астматай болох, бөөлжих огиудас хүргэх, суулгах, цусан дахь сахарын хэмжээ буурах, элэгний үйл ажиллагаа хордох, нойр булчирхайн үрэвсэл, нөхөн үржихүйн эрхтний хөгжилд муугаар нөлөөлөх зэрэг хорт нөлөө байдаг.

с. Кадми /Cd/– бол ямар нэг орчинд 20-оос ч илүү жилээр хоруу шинж чанараа хадгалсаар байдаг учир хоол хүнс, ундны ус болон хөрсөнд их хэмжээгээр хуримтлагддаг. Хүний биед кадми нь амьсгалын зам болон уушгийг цочроох, бөөрний чулуу бий болгох, элэг хордуулах, дархлал болон мэдрэлийн тогтолцоо гэх мэт олон төрлийн эрхтэн тогтолцооны эмгэгийг үүсгэх, сээр нуруу болон холбогч эрхтнүүдийн болон яс, цусны хүнд өвчлөлийг бий болгодог байна.

д. Хар тугалга – бол маш бага хэмжээтэй байсан ч хүний эрүүл мэндэд хортой, бүрэн аюулгүй болгож устгахаас нааш өөрөө байгаль дээр задарч алга болдоггүй хорт бодис юм. Хар тугалга нь хүний бараг бүх эрхтэн тогтолцоонд сөрөг нөлөө үзүүлдэг

орчныг бохирдуулагч хортой бодис юм. Хүний эрүүл мэндэд олон талаар сөрөг нөлөө үзүүлээд зогсохгүй хүний биед их хэмжээтэй агуулагдах нь үхэлд хүргэх аюултай. Хүний мэдрэл, бөөр, цус бүтээх, нөхөн үржихүйн тогтолцоонд сөргөөр нөлөөлдөг. Мөн хүүхдийн өсөлтийг саатуулах сөрөг нөлөөтэй. Ер нь хар тугалгыг мэдрэлийн хор гэж нэрлэдэг бөгөөд хүүхдийн тархины хөгжлийг саатуулах аюултай.

e. Хром – нь хөрс болон хромитыг агуулсан чулуулагт өргөн тархсан химийн бодис юм. Хром нь хүний биед арьс биржгэр болох, ходоодны үрэвсэл шархлаа үүсгэх, амьсгалын замын өвчлөл, дархлалын тогтолцоог бууруулах, элэг бөөр гэмтээх, генетикийн материалыг өөрчлөх, уушигны хорт хавдар үүсгэх, генийн өөрчлөлт болон DNA мутаци болгон өөрчлөх зэрэг хортой нөлөө үзүүлдэг.

f. Хүнцэл – бол байгаль дээр маш бага хэмжээгээр байдаг ч хамгийн их хортой элементүүдийн нэг юм. Хүнцлийн хор нь захын судасны өвчин, уушигны хавдар, арьсны хавдар, бөөр болон цөсний хавдар, ясны чөмөгний дутагдал, цусан дахь улаан эсийг устгах, элэг томруулах, арьсан дээр их хэмжээний толбо бий болгох, хэд хэдэн мэдрэлийг өвчлүүлэх, тархины үйл ажиллагааг алдагдуулах, зүрх судас болон төв мэдрэлийн тогтолцооны үйл ажиллагааг ноцтойгоор муутгаснаар үхэлд хүртэл хүргэх аюултай байдаг.

g. Хүчлээр уусгах – энэ нь хүдэр олборлолтын үед шүлтийг ашиглан газар дээр нь шүлтлэггүйжүүлэхэд ялгардаг химийн урвал юм. Ихэвчлэн хүхрийн хүчлийг ашиглан металлуудыг хүдрээс ялган авахад ашигладаг. Хүхрийн хүчил нь зэс, никел болон бусад олборлолтод ашигладаг маш аюултай, идэмхий бодисуудын нэг юм. Хэрэв энэ бодис ил задгай алдагдсан тохиолдолд хүн амьсгалахад хэцүү болгож мэднэ. Мөн нүд сохолж ч мэдэх аюултай ба залгисан тохиолдолд, гэдэсний ханыг түлж, гэмтээдэг. Харин арьсан дээр дууссан тохиолдолд арьсыг ноцтойгоор түлж мэднэ.

h. Уурхайн хаягдлын нуур – уурхайн олборлолт хийгдэж байгаа газарт нь дахин ашиглах зориулалт бүхий шүлтлэггүйжүүлэлтийн хүчлийг ихээр агуулсан, хорт мателлууд бүхий нуур байдаг. Уг хаягдлын нуур нь хаягдал шороо, эсвэл хүдрийг ялгаж авсаны дараа үлддэг хаягдал материалаар дүүргэсэн далан юм. Эдгээр далангууд нь маш хортой, радио идэвхт шингэн, хатуу, шингэн шавар, нарийн ширхэгт тоосонцруудыг агуулж байдаг бөгөөд бороо орох үед уг хорт бодисууд нь даланг хальж эргэн тойрны хөрс, газрын гадаргын ус, гол горхийг хордуулж, улмаар хөрсийг шүлтлэг болгодог байна. Харин хуурай цаг агаар бүхий хавар, намрын улиралд тус даланд агуулагдаж байсан хорт тоосонцрууд салхиар дамжин ойр орчмынхоо газарт тархаж, агаарыг бохирдуулснаар амьсгалын замын өмчлөл үүсэхэд нөлөөлдөг. Түүнчлэн ус, хөрсийг

бохирдуулснаар хүнсний бүтээгдэхүүн, голын амьтад болон ундны ус хорддог байна. Эдгээр хог хаягдлын далангууд нурснаар үхлийн аюултай хорт бодисууд далангаас хальж эрүүл мэндийг хохироогоод зогсохгүй, ямар хэмжээгээр задарснаас хамаарч хөрс болон усан дахь амьд биетүүдийг урт хугацаандаа хордуулж байдаг. Ийм учраас уурхайн хаягдлын даланд тусгайлан стандарт тогтоож, аюулгүй байдлыг хянаж, нэвчихгүй бас ууршихгүй байх технологиор барих шаардлага тавигддаг.

i. Ионжсон цацрагт идэвхт бодисууд – бага хэмжээгээр байгаль дээр байдаг цацрагт идэвхт бодисууд нь байгаль орчинд тийм ч хор хөнөөлтэй байдаггүй. Харин уурхай нь ихээхэн хэмжээний хаягдлыг үйлдвэрлэж байдагтай холбоотойгоор байгаль дээрх цацрагт идэвхт бодисын хэмжээ, хор хөнөөлийг тэр чинээгээр нэмэгдүүлж байдаг. Цацраг идэвхт бодист агуулагддаг гадионуклидын Уран-238 (238U), Тори-232 (232Th)-ын задралын цуваа нь хамгийн аюултай урвалж юм. Кали-40 (40K) буюу цуваа биш радионуклидыг санамсаргүй залгих болон идэхэд аюултай. Энэ тохиолдолд ямар хэмжээтэй цацрагт идэвхт бодис байснаас шалгаалж хор уршиг нь ялгаатай байдаг. Тодорхой хэмжээний заагаас хэтэрсэн цацрагт идэвхт бодис нь эд эс болон бие эрхтэний үйл ажиллагааг доголдуулж, арьс улайх, үс унах, цацрагт идэвхт бодисын түлэгдэлтийг үүсгэдэг.

j. Хорт хийнүүд – алтыг хүхрийн хүчил, азотын исэл, угарын хий зэрэг хорт хийнүүдээс ялгаж авахын тулд маш өндөр температурт халаадаг. Агааржуулалт байхгүй, жижиг орон зайд хорт хийн бөөгнөрөл үүсдэг бөгөөд эдгээр нь үхлийн аюултай. Азотын исэл, метан зэрэг тодорхой хийнүүд нь уурхайн олборлолтын үед задарч, орон зай багатай орчинд тархаж болдог. Ингэснээр эдгээр хорт хий нь цусан дахь хүчилтөрөгчийн оронд биед орж улмаар эд эсэд очих ёстой байсан хүчилтөрөгчийн хэмжээг эрс багасгадаг байна.

Жич: Уул уурхайн олборлолт явуулж буй компаниуд нь ямар химийн бодисыг, ямар хэмжээгээр хэрэглэж байгааг тайлагнах үүрэгтэй бөгөөд та бүхэн доорх цахим хуудсаар орж тухайн уул уурхайн компанийн химийн бодисын ашиглалтын тайлантай танилцан, мэдээлэл авч хянаж байгаарай.

www.eitimongolia.mn

Мөн байгаль орчны мэдээллийн сангийн <https://eic.mn/> сайтаас холбогдох нэмэлт мэдээлэл авч болно.



2.3 УУЛ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧИН, ХҮН АМЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ

Уул уурхайн үйл ажиллагаанаас хамгийн түгээмэл гардаг сөрөг нөлөөллийг доорх байдлаар ангилдаг байна:

- 1) Байгаль орчин;
- 2) Эрүүл мэнд;
- 3) Нийгэм;
- 4) Жендэртэй холбоотой нөлөө



Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл:

Газрын эвдрэл, доройтол.

Уул уурхайн үйл ажиллагаатай холбогдуулан зам тавих, уурхай барих, хаягдлын далан босгох зэрэг ажлууд нь газрын төлөв байдлыг их хэмжээгээр өөрчилдөг. Үүнтэй зэрэгцэж ой мод, ургамал доройтож устах үзэгдэл гарч болзошгүй бөгөөд энэ нь байгаль орчны олон хүчин зүйлсэд сөрөг нөлөөтэй, жишээ нь: ан амьтдын тоо, усны чанар хэмжээ гэх мэт.

Байр, гэр орон, амьдрах газраа алдах.

Уул уурхайн үйл ажиллагаа нь иргэдийн газрын эрх, өмчлөл өрх гэр, эзэмшлийн хөрөнгийн аюулгүй, найдвартай байдал, өрхийн бизнес түүний дэд бүтцэд аюул учруулж, ойр орчны дэд бүтэц, өвөлжөө хаваржаа болон барилга байгууламжид ихээхэн хохирол үүсгэдэг. Жишээ нь: Уул уурхайн компаниуд үйл ажиллагаагаа нүүдлийн бэлчээрийн талбай дээр давхцуулан авдаг учир нутгийн иргэдийн өвөлжөө, малын бэлчээрийг хамарч ихээхэн хэмжээний сөрөг нөлөөлөл, үл ойлголцол, зөрчилдөөн үүсгэдэг.

Усны чанар, хэмжээ.

Уул уурхайн үйл ажиллагаанд ус маш их хэмжээгээр хэрэглэгддэг учир ойр орчны усны нөөцийг бүрэн шавхах аюултай бөгөөд гадаргын болон гүний усыг ч бохирдуулах аюултай. Ялангуяа химийн бодис, хүчил ашиглаж баялгийг шавхах авах арга ашигладаг (металл болон нүүрсний уурхай) болон мөнгөн ус ба цианит ашигладаг уурхайд илүүтэйгээр үүсдэг (алтны уурхай). Цианит болон бусад химийн аюултай хог хаягдал нь гол горхи, хөрсөнд асгарч асар их хэмжээний хохирол учруулж байсан тохиолдлууд түүхэнд бичигдсэн байдаг бөгөөд үүний нэг жишээ бол Филиппин улсын Маркоппер зэсийн уурхайн хаягдал Боак гол руу урсаж орсон

явдал юм. Ийм хэмжээний асгаралт нь хүний эрүүл мэндийг муутгаж, ургац алдаж өлсгөлөнд нэрвэгдэх, усны ан амьтдын амьдралыг сүйрүүлэх аюултай.

Газрын бат бэх байдал

Гүний уурхайн хонгил болон бусад хөндий нурахад газрын гадаргууд доргилт өгдөг бөгөөд зарим тохиолдолд газар нуралт үүсч өвөлжөө хаваржаа, гэр орон сууц, байгууламжийг гэмтээж ханын цууралт үүсгэж аюултай байдал үүсгэдэг.

Тоосжилт, булингар.

Уул уурхай, тэр тусмаа ил уурхайн үйл ажиллагааны улмаас агаарын тоосжилт үүсэж, тариалангийн талбайд булингар үүсдэг.

Уул уурхайн хог хаягдал.

Хог хаягдлыг зориулалтын бусаар хаяж устгах нь тухайн нутгийн байгаль орчинг бохирдуулж, уугуул иргэдийн эрүүл мэндэд аюултай нөхцөл үүсгэдэг.



Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:

Ажлын байрны аюул.

Уул уурхайн ажилчид чулуу шавар унаж нурах аюултай орчинд ажилладаг бөгөөд үүнээс болж гэмтэх, амь насаа алдах хүртэл эрсдэлийг хүлээдэг. Түүнчлэн уурхайн орчин тоос шороо ихтэй тул амьсгалын замын өвчлөл (силикоз, уушгины тоосжилт гэх мэт) тусах магадлал өндөр байдаг. Мөн чимээ шуугиан ихтэй учир чих дүлийрэх, сонсгол алдах эрсдэлд бас өртдөг. Уул уурхайн ажил ихэвчлэн нөхөн үржихүйн насны эрэгтэйчүүдийг ажиллахыг шаарддаг төдийгүй ээлжийн хуваарь нь ажил болон ар гэрийн тэнцвэрийг харгалзаж үзэхгүй, гэр бүлээсээ 45 хоног хүртэл тусдаа байх нь элбэг. Энэ нь гэр бүлийн харилцаа, тогтвортой байдалд сөрөг нөлөөлж байдаг.

Арьс харшил, амьсгалын замын өвчин.

Уул уурхайн үйл ажиллагаанаас үүссэн тоосжилт нь орчны агаарт дэгдэж нарийн ширхэгт тоосонцрууд химийн бодис агуулагддаг тул нутгийн иргэд, компанийн ажилтнууд арьсны харшилтай болох, амьсгалын замын өвчин тусах зэрэг аюултай.

Бохирдсон ус хэрэглэх.

Хууль хяналтаас гадуур жижиг хэмжээний алт олборлолтод мөнгөн ус түгээмэл ашиглагддаг тул нутгийн иргэд болон мал, ан амьтдын уух усыг бохирдуулдаг.

Дуу чимээтэй холбоотой асуудлууд

Уул уурхай нь дуу чимээ ихтэй байдаг бөгөөд үүнээс болж нутгийн хүмүүсийн сонсох чадвар багасах, амархан уцаарладаг болох, стресстэх, даралт ихсэх зэрэг тохиолдлууд гардаг.



Нийгэмд үзүүлэх нөлөөлөл:

Амьжиргаа дордох.

Уул уурхайн нэн түрүүнд бодитой мэдрэгдэх сөрөг нөлөөлөл бол иргэд уламжлалт аргаар амьжиргаагаа залгуулах боломж бараг үгүй болдог. Энэ нь тухайн газар нутаг, малын бэлчээр нь компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайн нэг хэсэг болж, иргэдийн ашиглах боломжийг боомилдгоос үүдэлтэй. Үүнээс гадна, амьжиргаа дордох, өрхийн орлого буурах бас нэгэн шалтгаан бол бэлчээр доройтох, ус, хөрс бохирдох юм. Мөн малын бэлчээр багасч, өвсний гарц муудсанаар мал маллах уламжлалт аж ахуйгаас уул уурхайн салбар руу ажиллах хүч шилжих явдал гардаг бөгөөд ингэснээр тухайн нутгийн хүнс үйлдвэрлэл зогсох, хүнсний хүртээмж багасч, бүр хүнсний аюулгүй, баталгаат байдал алдагддаг.

Хүчирхийлэл, хүний эрх зөрчигдөх.

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэгч, тэднийг санхүүжүүлэгчид харуул хамгаалалтын алба, буу зэвсэгтэй этгээдүүдийг хөлсөлж уурхайн үйл ажиллагаа явуулахыг эсэргүүцсэн иргэдийг хүч хэрэглэн дарах, дарамтлах, эсвэл амь насанд нь хүрэх аюултай байдаг. Жишээлбэл, Филиппин улсын Карага бүсэд уугуул иргэдийн нутаг руу цэргийн хүч оруулсан нь тэр бүсэд үйл ажиллагаа явуулахаар санаархаж буй 5 том нүүрсний уурхайн компанийн үйлдэл хэмээн Уугуул иргэдийн өмгөөлөгчид үздэг. Үүний хор уршгаар их хэмжээний нүүлгэн шилжилт явагдаж, хэд хэдэн уугуул иргэд амиа алдсан байдаг.

Нийгмийн харилцаа гажуудах.

Уул уурхайн үйл ажиллагаа эхэлснээр тухайн газарт оршиж буй нийгмийн ангилал, түүний бүтэц болон ёс заншилд эрс өөрчлөлт ордог. Уурхайн компаниуд болон тэдэнтэй ашиг сонирхол нэгтэй төр засгийн газар нь уурхайн үйл ажиллагааг саадгүй явуулах үүднээс уурхайг сурталчилж, иргэдийн дунд хагарал үүсгэж, ашиг сонирхлын зөрчилтэй иргэдийг талцуулдаг. Уурхайн төслийг дагаж уурхайд ажиллах хүсэлтэй хүмүүс шинээр нүүж ирдэг. Иргэдтэй хийсэн хэлэлцүүлгээр Индонез улсын нэгэн нүүрсний уурхайд албан ёсны зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэдийг ажиллуулж байсныг тогтоожээ. Энэ асуудал МУ-ын нөхцөлд ч байхыг үгүйсгэхгүй.

Соёл, уламжлалын эрх зөрчигдөх

Уугуул иргэдийн газар нутгийг төдийлөн хуулиар хүлээн зөвшөөрч хамгаалдаггүйн зэрэгцээ тэдний эрт дээр үеэс амьдарч ирсэн газарт олборлолт хийх, ихэс дээдсийн оршиж буй газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл өгөх асуудал их байдаг. Тухайлбал, Завхан аймгийн Дөрвөлжин сумын Баян- Айраг ХХК нь нутгийн иргэдийн өвөг дээдсээ нутаглуулж, сүсэглэн биширдэг онгон дагшин газарт уул уурхайн олборлолт явуулж, тус уулыг ухаж төнхөн, өвөг дээдсийн шарилыг хөндсөн харамсалтай явдал гарч нутгийн иргэдийн итгэл үнэмшил, соёлыг үгүйсгэж айдас болгоомжлол, нийгмийн стресс үүсгэсэн байдаг.



Жендэртэй холбоотой нөлөөлөл:

Эмэгтэйчүүдийн оролцооны эрх хязгаарлагдах.

Уул уурхайтай холбоотой асуудлыг мэдээлэх, мэдээлэл авах, мэдээллээр хангагдах эрхэд огт ач холбогдол өгдөггүй, аливаа асуудлаар хэлэлцэж шийдвэр гаргах үйл явцад эмэгтэйчүүдийг төдийлөн оролцуулдаггүй, оролцох боломжоор хангадаггүй байна. Үүнээс болж эмэгтэйчүүд уурхайн сөрөг нөлөөллийг хянах, үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх, эрх зүйн зөвлөгөө авах, төслийн үр ашгийг хүртэх, боломжгүй болдог.

Бэлгийн аюулгүй байдал алдагдах.

Уул уурхайн ажилчдад чиглэсэн биеэ үнэлэлт ихэсдэг. Энэ нь бэлгийн замын өвчлөл, гэр бүлийн хүчирхийлэл, хүчээр биеийг үнэлүүлэх зэрэг хор уршгийг дагуулдаг. Мөн архидалт ихсэх нь эмэгтэйчүүдийг гэр бүлийн хүчирхийлэлд өртөх магадлалыг ихэсгэдэг. Эрчүүд уул уурхайд олон өдрөөр ажиллах нь алсдаа гэр бүл тусдаа амьдарч салалт ихэсдэг.

Санхүүгийн алдагдалд орох.

Уул уурхайн салбарт эрэгтэй ажиллах хүчний хэрэгцээ их байдаг тул ар гэрийн амьжиргаа эмэгтэйчүүдийн нуруун дээр ирж, тэдний хөдөлмөр эрхлэлт 2 дахин нэмэгдэж, уламжлалт аргаар амьжиргаагаа залгуулах боломж улам эрсдэлтэй, их цаг хүч зарцуулах болдог тул эмэгтэйчүүдэд эдийн засаг, санхүүгийн хувьд алдагдалд ордог. Ялангуяа ихэнх уул уурхайн бүс нутагт ус бохирдох, усны хомсдлоос үүдэлтэйгээр эмэгтэйчүүд ундны болон малаа хэвийн үеийнхээс 3 дахин их хүн хүч, цаг зарцуулж услах усаа холоос авах, малаа хангалттай усалж чадахгүйд хүрч энэ нь эмэгтэйчүүдийг малаас авах ашиг шим буурч, заримдаа бүрэн алдахад хүргэдэг.



БҮЛЭГ 3.

Уул уурхайн үйл
ажиллагаанд жендэрийн
үр нөлөөний үнэлгээ
хийх нь



03

Уул уурхайн үйл ажиллагаанд жендэрийн үр нөлөөний үнэлгээ хийх нь

3.1 ЖҮНҮ ХИЙХ ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ

ЖҮНҮ үр дүнтэй хийх цогц төлөвлөгөө боловсруулах. Энэ хэсэгт ЖҮНҮ хийх ажил эхлэхээс дуусах хүртэлх бүх арга хэмжээг алхам тус бүрээр төлөвлөж бэлтгэл ажлыг хангана. Доорх загвар хүснэгтийг ашиглан “ЖҮНҮ хийх цогц төлөвлөлт” хийж болох юм. Үүнд:

1. ЖҮНҮ хийх үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах

№	Үйл ажиллагаа	Хугацаа	Хэн хариуцах	Ямар нөөц шаардлагатай	Хэнтэй хамтарч болох
1.	ЖҮНҮ хийх багаа бүрдүүлэх		ЭТББ		Нутгийн иргэд, баг сумдын засаг дарга, эмэгтэйчүүдийн бүлэг
2.	ЖҮНҮ хийх уул уурхайн бүс нутгаа сонгох	1-2 долоо хоног	Багаараа	Тухайн уул уурхайн олборлолт хийх гэж буй, хийж буй, хаагдах гэж буй компани болон тэдний явуулж буй үйл ажиллагааны талаарх мэдээлэл	Нутгийн иргэд, баг сумдын засаг дарга, эмэгтэйчүүдийн бүлэг
3.	Сонгосон бүс нутгийн Уул уурхайн сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдийг тодорхойлох	1 долоо хоног	Багаараа	Уул уурхайн сөрөг нөлөөлөлд дам болон дам бус байдлаар өртөх магадлалтай олон нийт, эмэгтэйчүүдийг тодорхойлох, нөгөө талдаа тус уул уурхайгаас ашиг үр шим хүртэж байгаа бүлэг, хүмүүсийг тодорхойлох	Нутгийн иргэд, баг сумдын засаг дарга, эмэгтэйчүүдийн бүлэг

4.	Тухайн уул уурхайн төслөөс гарч болох байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, жендэрийн үр нөлөөг урьдчилан тодорхойлох		Багаараа	Ямар ямар асуудал, сөрөг нөлөөлөл гарч болохыг жагсаан бичих	Нутгийн иргэд, баг сумдын засаг дарга, эмэгтэйчүүдийн бүлэг
5.	ЖҮНҮ-г хийх мэдээлэл цуглуулах аргаа тодорхойлж, мэдээлэл цуглуулах		Багаараа		
6.	ЖҮНҮ-ний мэдээлэлд боловсруулалт хийх, нөлөөллийн ажил хийх төлөвлөгөө гаргах		Багаараа		
7.	ЖҮНҮ хийсэн ажлаа хаах, дараагийн үйл ажиллагаагаа төлөвлөх		Багаараа		

3.1.1 ЖҮНҮ хийх багаа бүрдүүлэх

ЖҮНҮ хийх багт ямар хүмүүс оролцуулах нь тус үнэлгээний чанар, үр дүнд шууд холбогдож байдаг тул багаа бүрдүүлэхдээ доорх бүлгүүдээс заавал төлөөлөл оруулбал зохимжтой. Үүнд:

- ЖҮНҮ хийх бүс нутгийг сайн мэддэг, тэнд удаан амьдарсан эмэгтэйчүүдийн төлөөлөл
- Тус бус нутгийн нөхцөл байдал, түүх соёлын мэдлэгтэй тухайн орон нутгийн настан
- Хэрэв тухайн орон нутагт хүний эрх, жендэрийн мэдрэмжтэй экологийн цагдаа байгаа бол тэдний төлөөллөөс оролцуулах

Иргэдэд: малчин өрхүүдийн хооронд бэлчээрийн маргаан үүснэ. Энэ нь өрхийн тэргүүн хооронд зөрчил үүсгэж амь амиа бодох хандлага бий болж уламжлалт саахалт хүний санаа нэг гэдэг заншил огт үгүй болсон.

Өндөр настан: Бэлчээр хайж нүүдэл суудал ойр ойрхон хийх нь тавгүй нөхцөл үүсгэж, замын ядаргаа авах, эд хөрөнгө хаягдах гээгдэх, замын эрсдэлд орох гэх мэт.

Хүүхдүүдэд: Ишиг хургаа үргэлж дагахгүй бол айлын малтай нийлэх нь ихэсч хүүхэд үргэлж малын бэлчээрт байх нь эрсдэл үүсгэнэ, ядуу айлын хүүхэд айлд зарцлагдах г м.

№	Уул уурхайн хайгуул, олборлолтоос гарах сөрөг нөлөөллүүдийг жагсааж бичих	Үзүүлэх нөлөөлөл			
		Хугацаа	Хэн хариуцах	Ямар нөөц шаардлагатай	Хэнтэй хамтарч болох
1.	Малын бэлчээр хорогдох				
2.	Ус бохирдох				
3.	Усны нөөц багасах, шавхагдах				
4.	Хөрс бохирдох				
5.	Хүн, мал өвчлөх хордох				
6.	Эрүүл мэндээрээ хохирох				

3.2 ЖҮНҮ ХИЙХ МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ АРГА ЗҮЙГЭЭ ТОДОРХОЙЛЖ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ

Уул уурхайн олборлолт ямар шатандаа явж байгаагаас хамааран мэдээлэл цуглуулах аргачлалыг сонгоно. Мэдээлэл цуглуулах дараах аргуудыг хослуулан ашиглаарай. Үүнд:

1. Үүсээд байгаа нөхцөл байдалтай холбоотой иргэдээс асуулга, ярилцлага авах, кейс цуглуулах
2. Газар дээрх бодит нөхцөл байдал болон үр нөлөөг ажигласан ажиглалт тэмдэглэл, фото болон видео баримтжуулалтууд хийх
3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлангуудаас мэдээлэл авах
4. Усны төвшингийн талаарх мэдээлэл, бүртгэлд дүн шинжилгээ хийх
5. Ус ашиглах гэрээ болон усны дүгнэлтийг ашиглах
6. Хөрсний бохирдлыг үнэлж байсан үнэлгээний тайлан мэдээ, харьцуулалт хийх
7. Газар ашиглах гэрээ түүний нөхцөлүүдийг ашиглах

Түүнчлэн хайгуул эхлэхээс өмнө тухайн нутгийн нөхцөл байдлыг баримтаар нотлох түүхэн мэдээллүүдийг хайгуулын дараах нөхцөл байдалтай харьцуулан баримтжуулах нь чухал гэдгийг анхаараарай. Энэ мэдээллийг БОННУ-ний тайлангаас авна.

1. Хайгуулын үе

Олборлолтын өмнөх үеийн нэг хэсэг болох Хайгуулын шатанд - ашигт малтмал хайх, олдсон газарт олборлолт хийхэд эдийн засгийн үр өгөөжийг үнэлэх үйл явц юм. Энэ шатанд ашигт малтмалын нөөцийн хэмжээ, ордын байршил зэргийг нарийвчлан тогтоодог (WAMA, 2019). МУ-ын хувьд энэ мэдээллийг ТЭЗҮ буюу Техник эдийн засгийн үндэслэл нэртэй тайлангаас авч болно.

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үеийн эрх зүйн зохицуулалтыг та бүхэн Зураг 1-с харж, ЖҮНҮ хийх алхмаа тодорхойлоорой. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг АМГТГ зохион байгуулдаг²¹.

Зураг 1. Хайгуулын зөвшөөрөл өгөх үйл явц



²¹ Хил Хязгааргүй алхам ТББ, Уул уурхай ба иргэдийн оролцоо (2020)

7.

Засгийн газрын баталсан солбицолд үндэслэн АМГТГ хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайг ялган, үндэсний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгсэлээр зарлана. Ингэхдээ сонгон шалгаруулалт явуулахаас 30 хоногийн өмнө зарлан мэдээлнэ.

8.

АМГТГ дуудлага худалдаанд оролцогчдын материалыг хүлээн авч санал ирүүлсэн дарааллаар бүртгэж авна. Сонгон шалгаруулалтын комисс байгуулна.

9.

АМГТГ санал ирүүлсэн ААН-ийн материалд Техникийн болон үнийн саналд үнэлгээ өгч хамгийн өндөр үнэлгээ авсан ААН-ийг шалгарсанд тооцон мэдэгдэж Тусгай зөвшөөрлийн төлбөр төлснөөр Хайгуулын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ олгоно.

- төрийн захиргаа, ЗГ оролцоо ● иргэдийн оролцоо ● орон нутгийн захиргааны оролцоо

Хайгуулын эрх олгох үед эмэгтэйчүүдийг шийдвэр гаргах үйл явцад хэрхэн оролцуулж, саналыг тусгаж байсныг үнэлэхдээ дараах асуулгыг ашиглаж болно.

Компанийн талаарх ерөнхий мэдээлэл	Хариултуудыг бөглөж бичих	Тайлбар
Хайгуулын төслийн нэр		
Хайгуул явуулж буй компанийн нэр		
Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч		
Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй эсэх		
Хайгуул явуулах зорилго, чиглэл (алт, зэс, мөнгө, нүүрс гэх мэт)		

№	Асуултууд	Өөрийн хариултыг сонголтуудаас дугуйлах
ХАЙГУУЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ҮЙЛ ЯВЦ		
1	Танай орон нутагт уул уурхайн хайгуул явуулах гэж байгаа талаар та анх хэзээ сонссон бэ?	20. . оны . . сар Би мэдээгүй юм байна
2	Энэ талаар та анх хаанаас, ямар эх сурвалжаас мэдээлэл авсан бэ?	<ul style="list-style-type: none"> o Орон нутгийн удирдлагуудаас o Хөрш, саахалт, найз нөхдөөсөө o Би өөрөө мэдсэн o Бусад газраас: o Би мэдэхгүй байна
ХАЙГУУЛ ХИЙХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИЛ ТОД БАЙДАЛ		

	Асуултууд	Тийм	Үгүй	Мэдэхгүй
3	Та хайгуулын тусгай зөвшөөрлийн явуулах бичиг баримт, түүний хуулбартай танилцсан уу?			
4	Танай орон нутагт хайгуул явуулж буй компанийн жил бүрийн “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-тэй танилцсан уу?			
5	Та тухайн компанийн жилийн хайгуулын ажлын төлөвлөгөөтэй танилцсан уу?			
6	Та тухайн компани танай орон нутгийн засаг захиргаатай байгуулсан хамтын ажиллагааны гэрээтэй танилцсан уу?			
7	Та тус компанийн газар ашиглах гэрээ, жил бүрийн тайлантай танилцсан уу?			
8	Та тус компанийн ус ашиглах гэрээ, жил бүрийн тайлантай танилцсан уу?			
9	Танд дээр дурдсан мэдээллүүдийг авах боломжийг компани олгосон уу?			
10	Танд компанийн талаарх дээрх олж авсан мэдээлэл дээр өөрийн санал бодлоо хэлэх, шийдвэрт саналаа тусгуулах боломж олгосон уу?			
11	Иргэдэд компанитай холбоотой шийдвэр гаргалтад оролцох, хамтран ажиллах, хяналт мониторинг хийх боломж байсан уу?			

Бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах боломжтой. Ингэхдээ доорх жишиг асуултуудыг ашиглаарай. Үүнд:

- Та бүхэнд тус хайгуул хийх гэж буй, хийж буй компанийн талаарх мэдээллийг авах боломж хэр байсан бэ?
- Компанийн зүгээс та бүхэнд бичгээр, ямар нэг уулзалт хийж мэдээлэл хүргэсэн үү?
- Уулзалтыг зохион байгуулах мэдээллийг та яаж мэдэж авсан бэ? Танд бичгээр зар ирж байсан уу? Хэрэв тийм бол бидэнд үзүүлэхгүй юу? (боломжтой бол хуулбарыг авах, гар утсаараа зургийг нь дарах)
- Хэрэв тийм бол та бүхэнд тус компанийн хайгуулын үйл ажиллагаатай холбоотой өөрийн саналаа хэлэх, эрх ашгаа хамгаалахад саналаа тусгах боломж нь ямар байсан бэ? Ялангуяа эмэгтэйчүүдэд учирч болох сөрөг нөлөөлөлтэй холбоотой шийдвэр гаргалтад оролцох боломж байсан уу?
- Тус хайгуулын компани нь таны амьдарч буй газар, тухайлбал өвөлжөө болон

малын бэлчээр дээр хайгуул хийхдээ танд мэдээлсэн үү? Зөвшөөрөл авсан уу? Хайгуул хийх зөвшөөрлөө үзүүлсэн үү?

- Хайгуулын компани нь хайгуул хийхдээ таны амьдардаггүй ч гэсэн сүсэглэн биширдэг уул ус, дов толгодод гэх мэт түүх соёлын газарт хайгуул хийхдээ та бүхнээс зөвшөөрөл авсан уу?
- Зөвшөөрөл авсан бичиг байгаа эсэх
- Хайгуулын компани нь та бүхний хэрэглэдэг усыг авч хэрэглэдэг үү? Хүн болон малын ундны усны хэрэглээнд ямар нэг өөрчлөлт оруулсан уу? (усны нөөцийг багасгасан, бохирдуулсан гэх мэт)
- Тус хайгуулын компанийн үйл ажиллагаа эхэлснээр таны амьдрах орчин, нөхцөл байдалд өөрчлөлт орсон уу? (дуу чимээ их гарах болсон, тоосжилт нэмэгдсэн, малаа бэлчээх газраа өөрчилсөн, нүүх шаардлагатай болсон, худаг уснаасаа холдсон гэх мэт)
- Таны болон танай гэр бүлийн гишүүдийн аюулгүй амьдрах нөхцөл өөрчлөгдсөн үү? (хайгуулын үйл ажиллагаатай холбоотой компанийн зүгээс эсвэл төр захиргааны байгууллагаас ямар нэг дарамт шахалт ирсэн үү? Нутаг орноосоо нүүхийг шаардсан уу? Олон танихгүй хүмүүс танай нутагт нүүж ирсэн үү? Архидалт нэмэгдсэн үү гэх мэт)
- Бусад нэмэлт асуултууд

2. Олборлолт явуулахаас өмнөх үе

Олборлолтын өмнөх үе нь хайгуулын дараа явагддаг бөгөөд, уурхай нь ашигт малтмалд хүрэхийн тулд малталт, агааржуулалт хийх, эрчим хүч холбох, уурхайчдын орц гарцыг гаргах, тэдний хангамж болон тоног төхөөрөмжийг байршуулах зэрэг үйл ажиллагааг төлөвлөж, шаардлагатай барилга байгууламжийг барьж байгуулдаг (WAMA, 2019). Манай улсад энэ үе шатыг “ашиглалтын өмнөх үе шат” гэж нэрлэдэг.

Хувийн хөрөнгөөр нөөц тогтоосон талбайд ашиглалтын лицензийг өргөдөл хүлээн авах журмаар олгох дараалал (Зураг 2)

Зураг 2. Ашигт малтмалын зөвшөөрөл өгөх үйл явц



● Төрийн захиргаа, ЗГ оролцоо ● Орон нутгийн захиргааны оролцоо ● Иргэдийн оролцоо

Энэ үе шатанд ЖҮНҮ-г хийхдээ одоогийн хэрэгжиж байгаа хууль эрх зүйн хүрээнд ашигт малтмалын зөвшөөрөл авах процесс хэрхэн явагддагтай (Зураг 2) нарийвчлан танилцаж, ЖҮНҮ мэдээлэл цуглуулах, баримтжуулалт хийх арга зүйгээ тодорхойлоорой.

Ашигт малтмалын зөвшөөрөл авах үйл явцын хэлэлцүүлэг уулзалтад эмэгтэйчүүдийг хэрхэн оролцуулсан, санал бодлоо тусгуулах, шийдвэр гаргалтад оролцох боломжийг хэрхэн олгосныг дараах асуулга болон ярилцлагын аргаар баримтжуулаарай. Олборлолт явагдсанаар та бүхний амьдрах орчинд гарах сөрөг нөлөөллийн талаар хангалттай мэдээлэл өгч байсан уу, цаг хугацааны хувьд хэрэгтэй байж чадсан эсэхийг тодруулахыг үнэлгээ хийж буй баг эрмэлзэнэ.

Компанийн талаарх ерөнхий мэдээлэл	Хариултуудыг бөглөж бичих	Тайлбар
Олборлолт хийх төслийн нэр		
Олборлолт хийх компанийн нэр		
Хөрөнгө оруулагч, санхүүжүүлэгч		
Олборлолт явуулах зөвшөөрөлтэй эсэх		
Олборлолт явуулах зорилго, чиглэл (алт, зэс, мөнгө, нүүрс гэх мэт)		

№	Асуултууд	Өөрийн хариултыг сонголтуудаас дугуйлах		
---	-----------	---	--	--

ХАЙГУУЛ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ҮЙЛ ЯВЦ

1	Танай орон нутагт уул уурхайн олборлолт явуулах гэж байгаа талаар та анх хэзээ сонссон бэ?	20. . оны . . сар	Би мэдээгүй юм байна	
2	Энэ талаар та анх хаанаас, ямар эх сурвалжаас мэдээлэл авсан бэ?	о Орон нутгийн удирдлагуудаас о Хөрш, саахалт, найз нөхдөөсөө о Би өөрөө мэдсэн о Бусад газраас: о Би мэдэхгүй байна		

ОЛБОРЛОЛТ ЯВУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ АВАХ ҮЙЛ ЯВЦ ДАХЬ ИЛ ТОД БАЙДАЛ

	Асуултууд	Тийм	Үгүй	Мэдэхгүй
3	Орон нутгийн иргэдтэй уурхайн олборлолт явуулах гэж байгаа талаар Зөвлөлдөх уулзалт хийсэн үү?			
4	Танд олборлолт явуулахыг эсэргүүцэх, татгалзах сонголт байсан уу?			
5	Та олборлолт явуулах компани орон нутгийн захиргаа/аймаг, яамтай байгуулсан гэрээ эсвэл Хамтын ажиллагааны гэрээний талаар мэдэх үү?			
6	Олборлолт нь танай нутгийн иргэдийн нийгэм-соёлын асуудалд (жишээ нь шилжилт хөдөлгөөн ихсэх, архидалт нэмэгдэх, биеэ үнэлэлт бий болох, хулгай гарах, гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдэх гэх мэт) шууд болон шууд бус байдлаар үзүүлэх үр нөлөөг үнэлсэн эрсдэлийн үнэлгээний талаар та мэдэх үү?			
7	Олборлолт явуулах компанийн хийлгэсэн байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ (БОНБНУ) хийлгэсэн талаар мэдэх үү?			

8	Танай сум, багийн иргэдийн нийтийн хуралд \БИНХ\ энэ үнэлгээний талаар дэлгэрэнгүй танилцуулга хийсэн үү? Та ийм уулзалт арга хэмжээний талаар сонсож байсан уу?			
9	Та өөрөө болон таны гэр бүлийнхэн энэ танилцуулга арга хэмжээнд оролцсон уу?			
10	Тус компани болон үнэлгээний компани БОНБНУ-ний тайлангийн хураангуйг урьдчилан та бүхний гар дээр ирүүлж урьдчилан мэдээлэлтэйгээр оролцох боломжийг хангасан үү?			
11	Энэ үнэлгээнд эмэгтэйчүүд оролцож, санал бодлоо тусгасан уу?			
12	БОНБНУ-ний нэг хувь сумын засаг даргад байдгийг та мэдэх үү?			
13	БОНБНУ-ний тайлантай танилцах хүсэлт та гаргаж байсан уу			
14	Засгийн газар/нутгийн захиргаа таны эрхийг хамгаалах тал дээр дэмжлэг туслалцаа үзүүлсэн үү?			
15	Засгийн газар/нутгийн захиргаа олборлолт явуулах гэж байгаа компанитай хамтарч иргэдийн эсрэг ямар нэг шууд болон шууд бус үйл ажиллагаа явуулсан уу			

УУРХАЙ ХААХТАЙ ХОЛБООТОЙ МЭДЭЭЛЭЛ

16	Олборлолт дууссаны дараа байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайг хаахтай холбоотой ямар нэг мэдээллийг компани та бүхэнд өгсөн үү? Энэ талаар танилцуулга мэдээлэл өгсөн үү	Тийм	Үгүй	Мэдэхгүй
17	Компани үйл ажиллагаа явуулж эхлэхийн өмнө орон нутгийн иргэдэд дараах амлалтуудаас алийг нь өгсөн бэ? (хэдэн ч хариулт сонгон, дугуйлж болно)			
	• Ажлын байр (эрэгтэй, эмэгтэйчүүдэд зориулсан) нэмэгдүүлэх			
	• Дэд бүтэц хөгжүүлэх			
	• Сургууль, цэцэрлэг барих			
	• Эрүүл мэндийн төв байгуулах			
	• Худаг гаргаж өгөх			
	• Орон нутгийн төсөвт мөнгөн хандив өгөх			
	• Баяр ёслолын үеэр малчдад бэлэг тараах			
	• Малчдад оюутны сургалтын төлбөрийг төлж өгөх			
	• Бусад			

Дээрх асуулгаас гадна хагас бүлгийн ярилцлага эсвэл ганцаарчилсан ярилцлага хийх замаар илүү дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах боломжтой.



ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТУУД:

- Танай нутгийн захиргаа тус уул уурхайн тусгай зөвшөөрлийг олгох явцад иргэдээсээ тэр дундаа эмэгтэйчүүдээс асуусны үндсэн дээр зөвшөөрөл олгосон уу?
- Танай орон нутагт уул уурхайн олборлолт явуулах талаар болон түүнтэй холбоотой ямар нэг асуудлаар зөвлөлдөх уулзалт зохион байгуулагдсан уу?
 - Энэ үеэр эмэгтэйчүүдэд өөрсдийн санал бодлоо тухайн орон нутгийн эрэгтэйчүүдийн дарамт шахалтаас ангид чөлөөтэй, нээлттэйгээр хэлэх боломжийг компани хэрхэн бүрдүүлсэн бэ?
- Уул уурхайн компани нь тухайн олборлолт явуулах гэж байгаа орон нутгийн Захиргаатай Хамтын ажиллагааны гэрээ байгуулдаг бөгөөд та ийм хамтын ажиллагааны гэрээний талаар мэдсэн үү?
 - Тус хамтын ажиллагааны гэрээнд юу юу заасан талаар мэдэж байсан уу? Та гэрээний эх хувилбарт гарсан ямар нэг гажуудлын талаар мэдэж байсан уу? (жишээ нь олборлолт явуулах газрын хэмжээ гэрээнд зааснаас ихсэх гэх мэт)
- Олборлолт явуулахтай холбогдуулан Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын ерөнхий болон Нарийвчилсан Үнэлгээний \БОНБНУ\ талаар та сонсож байсан уу? Ийм үнэлгээний танилцуулах уулзалт хэлэлцүүлэгт оролцож саналаа илэрхийлж байсан уу? Энэ үнэлгээг тус компани хийсэн болов уу? Хэрэв тийм бол:
 - Хэн энэ үнэлгээг хийсэн бэ?
 - Энэ үнэлгээнд эмэгтэйчүүд оролцож, санал бодлоо тусгасан уу?
 - Үнэлгээний үр дүнд ямар нэгэн өөрчлөлт тусгагдсан уу?
- Олборлолтын үйл ажиллагааны эмэгтэйчүүдэд үзүүлэх тодорхой сөрөг үр нөлөө нь юу байх вэ? Энэ асуудлын хүрээнд таны санал болгосон зүйлс юу байсан бэ?
- Уул уурхайн дэд бүтэц, барилга байгууламжийн ажилд орон нутгийн иргэдээс ажилд авч байсан уу? Ялангуяа эмэгтэйчүүдэд ажилд орох тэгш боломж байсан уу?
- Олборлох уурхайг эсэргүүцсэн үйл ажиллагаа болсон уу? Тэр арга хэмжээнд эмэгтэйчүүд оролцсон уу? Энэ үеэр баривчилгаа, хорих цагдах, хүчирхийлэл,

айлган сүрдүүлэлт, дарамтлах, үл тоох, хайхрахгүй байх гэх мэт ямар нэгэн хүний эрхийн зөрчил гарч байсан уу? Таны сэтгэлийг зовоосон асуудал байна уу?

- Танай орон нутагт уул уурхайн олборлолт явуулахад засгийн газрын/нутгийн захиргааны үүрэг, оролцоо ямар байсан бэ? Засгийн газар/нутгийн захиргаа компанитай хамтарч иргэдийн эсрэг шууд болон шууд бус замаар ямар нэг үйл ажиллагаа явуулсан уу?
- Олборлолт дууссаны дараа байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайг хаахтай холбоотой ямар нэг мэдээллийг компани та бүхэнд өгсөн үү? Энэ талаар танилцуулга мэдээлэл өгсөн үү? Тус танилцуулга мэдээнд уурхай хаагдсаны дараа орон нутгийн иргэдийн амьдрал, амьжиргаанд гарах өөрчлөлтийг хэрхэн хэвийн болгох талаар ямар нэг төлөвлөгөө дурдсан байсан уу?
- Олборлолт дууссаны дараа тухайн орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдийн амьдралд ямар зэрэг өөрчлөлт бий болсон байх талаар хаалтын төлөвлөгөөнд туссан уу?

3. Олборлолтын үе

Олборлолтын үед уурхай нь орд газраас газрын гүнээс ашигт малтмал агуулж буй хүдрийг гаргаж авах өдөр тутмын үйл ажиллагаа бөгөөд орд газраас гаргаж авсан хүдрээс ашигт малтмалыг салгах, бусад хэрэггүй хог шороог ялгах боловсруулалт зэрэг хийгдэж болно. Үүнд баяжуулах болон цэвэршүүлэх үйл явц орж болох бөгөөд эдгээр үйлдвэрлэлийн процесс ихэвчлэн уурхайн ойр орчимд хийгддэг (WAMA, 2019).

Олборлолтын үеийн хууль эрх зүйн зохицуулалт:

Хуулийн нэр, заалт

Тайлбар

Энэ шат нь уул уурхайн үйл ажиллагааны хамгийн урт хугацаа бөгөөд тиймээс сөрөг нөлөөлөл хамгийн ихээр үүсдэг тул эмэгтэйчүүд, эрх мэдэл багатай бүлгийн эрх ашигт хамгийн ихээр нөлөөлөл үзүүлдэг. Энэ шатандаа иргэдийн оролцоо бодитой, утга учиртай баталгаажихаар хуульчлагдах ёстой ч одоогоор МУ-ын хувьд тэр хэмжээнд хүрээгүй байна. Энэ шатанд олон мэдээлэл нээлттэй байхаар, иргэдэд мэдээлэхээр хуульчлагдсан ч, мэдээллийг аваад иргэд хэрхэн эрхээ урьдчилан сэргийлж хамгаалах, хэрэв зөрчигдсөн тохиолдолд хэрхэн эрхээ хэрхэн сэргээх талаар аль ч хуулиар зохицуулагдаагүй байна.

Ашигт малтмалын тухай хууль

<p>27.1.12. Энэ хуулийн 48.6.1-д заасан тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байх;</p>	<p>1.ТЭЗҮ-г зөвхөн АМГТГ-ын ажлын байранд сууж танилцах боломжийг иргэдэд олгосон байдаг тул хөдөө орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдэд тэр бүр ээлтэй зохицуулалт биш болдог ч төлөөлж чадах ТББ болон иргэдийг явуулж мэдээлэл авч болно.</p>
<p>39.1.2 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тухайн уурхайн ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох;</p>	<p>2. БОНБНУ- нь сумын засаг даргад нэг хувь байх тул түүнийг мөн ажлын байранд очиж танилцан мэдээлэл авах боломжтой.</p>
<p>39.1.3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн, амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах;</p>	<p>3. БОНБНУ-д үндэслэн жил бүрийн хэрэгжүүлэх БОМТ-г компани байр/кемпэд очиж үзэх замаар мэдээлэл авч түүний хэрэгжилтийг шаардах боломжтой</p>
<p>42.3.Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн болон түүний байгаль орчныг нөхөн сэргээх үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих үүрэг бүхий төлөөлөгчийг иргэд дундаасаа сонгон ажиллуулж болно.</p>	<p>4. Багийн Иргэд нэгдээд нөхөн сэргээлт хийж байгаа эсэх, түүний чанар дээр хяналтаа хэрэгжүүлэх боломжтой. Мөн хийгээд орхисон нөхөн сэргээлт дээр бичил уурхай оруулахгүй байхад хяналт тавьж хэрэв бичил уурхайчид орвол Засаг дарга болон тухайн компанийн удирдлагуудад мэдээлэх боломжтой.</p>
<p>41.1.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь хайгуулын болон ашиглалтын үйл ажиллагааны явцад худаг, өвөлжөө, хувийн болон нийтийн зориулалттай орон байр бусад барилга байгууламж болон түүх, соёлын дурсгалт зүйлсэд гэм хор учруулсан бол хохирлыг нь өмчлөгч, эзэмшигчид бүрэн хэмжээгээр нөхөн төлөх бөгөөд шаардлагатай тохиолдолд тэдгээрийг шилжүүлэн байрлуулахтай холбогдсон зардлыг хариуцна.</p>	<p>5. Нөхөн төлбөр авах эрхийг хуульчилсан хэдий ч хэрхэн хандах процедур, хохирол болон нөхөн төлбөрийг шударга үнэлж тогтоох аргачлал, стандарт манайд байхгүй. Харин тухайн компанийн үзэмж, дотоод бодлогоор тодорхойлогдож харилцан адилгүй байдаг.</p>

57.4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан, байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлж болзошгүй химийн хорт болон бусад бодисын хэрэглээний талаарх мэдээллийг байгаль орчны болон геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нийтэд нээлттэй болгож, тухайн мэдээллийг цахим хэлбэрээр түгээнэ

4. БОНБНУ-г заавал Багийн ИНХ-д танилцуулж тэмдэглэл, зураг, тогтоолоор баталгаажуулах тул иргэд багийн ИНХ-даа оролцох замаар тухайн төслийг дэмжих эсэх, хэрэв ажилласан тохиолдолд иргэд, эмэгтэйчүүд, орон нутгийн захиргааны эрх ашгийг хэрхэн хангаж ажиллах талаар энэ хэлэлцүүлэг дээр хэлж зөвшилцөж амлалт авахуулах цорын ганц боломж нь байдаг. Харин иргэдээ өргөнөөр оролцуулах, хэлэлцэх асуудлаа сайн танилцуулах, хэрэв ирц бүрдээгүй бол дахин хуралдуулахад хяналт тавьж шаардах боломжтой.

Байгаль хамгаалах тухай хууль

4 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах талаарх иргэний эрх, үүрэг: 1. Иргэн байгаль орчныг хамгаалах талаар дараах эрхийг эдэлнэ:

1. гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;
2. байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;
3. байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;
4. холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;
5. байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах;
6. байгалийн баялгийг хууль бусаар ашигласан, гэмтээсэн, хөнөөж сүйтгэсэн үйлдлийг олж мэдсэн иргэн тэр тухайгаа тухайн орон нутгийн Засаг дарга, улсын байцаагч, байгаль хамгаалагчид нэн даруй мэдэгдэх.

Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар иргэний эрх үүргийг уул уурхайн салбарын хуулиас арай илүү өргөн хүрээнд хуульчилж өгсөн байдаг.

Иймээс иргэд:

- зөрчлийг баримтжуулан мэдээлж болно
- төрийн байгууллага, албан тушаалтныг үүргээ хэрэгжүүлэхийг шаардаж болно.
- холбогдох мэдээллийг хүсч болно
- эвлэлдэн нэгдэж бүлэг хоршоо ТББ байгуулан ажиллаж болно.
- зөрчигдсөн эрхээ хамгаалуулахаар шүүхэд хандаж болно. Заавал өөрийн эрх зөрчигдсөн байх албагүй.
- Засаг даргыг иргэдийнхээ эрх ашгийг хамгаалж шүүхэд нэхэмжлэл гаргахыг шаардаж болно
- Зөрчил илрүүлж мэдээлсний төлөө урамшуулал авч болно.
- Аливаа зөрчлийг арилгуулах, нөхөн төлүүлэхээр эдийн засгийн цагдаагийн албанд хандаж болно

32 дугаар зүйл. Байгаль орчныг хамгаалахад төрийн бус байгууллага оролцох

Байгаль орчин, түүний баялгийг хамгаалах дүрмийн зорилго бүхий олон нийтийн байгууллага болон байгалийн нөөцийн хамтын менежмент эрхлэн явуулах нөхөрлөл байгаль орчныг хамгаалах талаар дараах үйл ажиллагааг хэрэгжүүлж болно:

1/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлтэд олон нийтийн хяналт тавих, үзлэг хийх, илэрсэн зөрчлийг арилгахыг шаардах, уг асуудлыг эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх, гэм буруутай этгээдээс байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

2/байгаль орчныг хамгаалах талаарх саналаа төрийн захиргааны төв байгууллага болон зохих шатны Хурал, Засаг даргад уламжлах;

4/байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх төсөл, зөвлөмж, аргачлал боловсруулж холбогдох байгууллагад танилцуулж шийдвэр гаргуулах.

54.4.Байгаль орчны хууль тогтоомж зөрчсөн тухай үнэн бодит мэдээллийг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд өгсөн, түүнчлэн зөрчлийг илрүүлсэн, илрүүлэхэд бодитой туслалцаа үзүүлсэн иргэнд зөрчил гаргагчид ногдуулсан торгууль, нөхөн төлбөрийн орлогын дүнгийн 15 хувьтай тэнцэх мөнгөн урамшууллыг сум, дүүргийн Засаг дарга байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос олгоно.

57.2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчны алдагдсан тэнцлийг болон байгалийн баялгийг нөхөн сэргээх, хүн амыг нүүлгэх, мал, амьтныг тухайн нутаг дэвсгэрээс шилжүүлэхэд гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээр сум, дүүргийн Засаг дарга шүүхэд нэхэмжлэл гаргана.

Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

Нийтийн эрх ашгийн өмгөөлөл хийх эрхийг ТББ-д олгосон. Шүүхэд эрхээ сэргээлгэхээр хандах боломжтой болсон 46.3.Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжилж байгаа этгээдийг шүүхийн зардлаас чөлөөлнө

- Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх
- тухай хуулиар байгаль орчин, хүний
- эрхтэй холбоотой нийтийн эрх ашгийг ТББ
- төлөөлөн нэхэмжлэх эрхийг хуульчилсан

Уул уурхайн олборлолтын үед хийх ЖҮНҮ нь үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Нэгдүгээр хэсэг – Орон нутгийн эмэгтэйчүүд

Хоёрдугаар хэсэг – Олборлох уурхайн компанид ажиллаж буй орон нутгийн эмэгтэйчүүд

Нэгдүгээр хэсэг.

Олборлолт явагдаж буй газар нутагт амьдарч буй орон нутгийн эмэгтэйчүүдээс асуух асуулт

I. Ерөнхий мэдээлэл:

1. Байршил: (олборлолт хийж буй газар):
2. Уурхайн компанийн нэр:
3. Олборлолтын төрөл:
4. Санхүүжилт, хөрөнгө оруулалт нь хаанаас вэ?

5. Асуулга авч буй огноо: 20. . оны . . сарын . . . өдөр

II. Олборлолт явуулах зөвшөөрөл авсан үйл явц

Олборлолт явуулах зөвшөөрөл авах үйл явцад орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдийг хэрхэн оролцуулж байсныг үнэлэхдээ өмнөх бүлэгт буюу “Олборлолтын өмнөх үе шат”-нд хэрэглэж байсан асуулга, ярилцлагын асуултуудыг ашиглах боломжтой.

III. Олборлох уурхайгаас гарах нөлөөллийг ЖҮНҮ тусламжтайгаар үнэлэх асуулга

1. Олборлох уурхайн төсөл эхэлснээс хойш таны ажил үүрэгт ямар нэг өөрчлөлт орсон уу? (Жишээ нь усаа илүү хол газраас очиж авдаг болсон, эрчүүд нь өөр газар очиж ажил хийх шаардлагатай болсон гэх мэт)
 - o Тийм
 - o Үгүй
 - o Би энэ талаар мэдэхгүй байна
2. Танай гэр бүл ямар нэг газар өмчилдөг үү? Тийм бол хэний нэр дээр байдаг вэ?
 - o Тийм, хэний нэр дээр байдаг вэ?
 - o Нөхөр
 - o Эхнэр
 - o Эхнэр, нөхрийн хамтын эзэмшилд
 - o Үгүй
3. Та уурхайн олборлолтоос болж өмчилж байсан газраа алдсан уу?
 - o Тийм
 - o Үгүй, дараагийн асуултыг алгасна уу.
4. Таныг болон танай гэр бүлийг олборлолт явуулахтай холбоотойгоор хүчээр танай эзэмшлийн газраас хөөн гаргасан уу?
 - o Тийм
 - o Үгүй, дараагийн асуултыг алгасна уу.
5. Та болон танай гэр бүлийн эзэмшлийн газрыг авсныхаа төлөө уурхайн компани танайд ямар нэгэн нөхөн төлбөр өгсөн үү?
 - o Тийм
 - o Үгүй
 - o Мэдэхгүй
6. Та уурхайгаас болж орон байрнаасаа нүүх, өвөлжөө хаваржааны нутгаасаа нүүх шаардлагатай болсон уу?
 - o Тийм, танд нөхөн төлбөр өгсөн үү?
 - o Тийм
 - o Үгүй

7. Энэ олборлолтын төсөл эхлэхээс өмнө таны орлого олдог гол эх үүсвэр юу байсан бэ?
 - o Газар тариалан, хүнсний ногоо тариалалт
 - o Мал аж ахуй, сүү сааль, ноос ноолуур
 - o Тахиа, шувууны аж ахуй
 - o Байгалийн баялаг, жимс жимсгэнэ, чацаргана, суль, сульхир
 - o Бусад
8. Олборлолт эхэлснээс хойш таны орлого олох энэ үйл явцад ямар нөлөө үзүүлсэн бэ?
 - o Орлого буурсан
 - o Орлого өссөн
 - o Одоогоор хэлж мэдэхгүй байна
9. Олборлолт эхэлснээс хойш танай орон нутаг зам тээврийн ямар нэг аваар осол гарсан уу?
 - o Тийм
 - o Үгүй
 - o Би энэ талаар мэдэхгүй байна

Эрүүл мэнд, байгаль орчин, нийгэм- соёлын нөлөөлөл

1. Байгаль орчны нөлөөлөл:

№	Олборлолт эхэлснээс хойш танай орон нутагт дараах байгаль орчны сөрөг нөлөөллүүд гарсан уу?	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1.	Ус/гол горхи багасах, ширгэж алга болох			
2.	Хөрс бохирдож, хуурайших, цөлжилт явагдах (өвс ургамлын гарц муудах гэх мэт)			
3.	Агаар бохирдох			
4.	Дуу чимээ нэмэгдэх			
5.	Ой мод багасах, устах			
6.	Ургац хураалт багасах, боломжгүй болох			
7.	Хүнсний хүртээмж багасах			
8.	Ойгоос түүдэг эмийн ургамал багасах, алга болох			
9.	Бусад:			

Жич: Байгаль орчны нөлөөлөлтэй холбоотой дараах нэмэлт мэдээллийг мөн цуглуулаарай.

Үүнд:

1. Усны хомсдол, бохирдол, гол горхи ширгэсэн асуудал байгаа талаар тухайн орон нутгийн иргэд асуулга, ярилцлагын үеэр хэлсэн бол БОАЖЯ , орон нутгийн холбогдох төрийн байгууллага, Усны сав газраас тухайн усны хэмжээ хэвийн байсан талаарх баримтыг авч, уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор багасч байгаа, бохирдсон байгааг мэргэжлийн байгууллага, хүмүүсийн тусламжтайгаар баримтжуулна.
2. Хөрсний бохирдол, эвдрэлтэй холбоотой асуудал байна гэж асуулга, ярилцлагаар гарсан бол тухайн хөрсний бохирдол, эвдрэл гэмтэл хэрхэн явагдсан талаар уурхайн өмнөх дараах харьцуулсан фото зураг авах, мэргэжлийн лабораторид хөрсний шинжилгээг хийлгүүлэх зэргээр баримтжуулах боломжтой.
3. Мөн уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор ой мод болон бэлчээрийн шимт ургамал багасах, устгах, ан амьтан, шувууд болон эмийн ургамлууд ургахаа больж ховордож устсан гэсэн мэдээллийг нутгийн иргэд, эмэгтэйчүүд өгсөн бол энэ сөрөг нөлөөллийг байгаль орчны байцаагч, экологийн цагдаа, болон бусад мэргэжлийн хүмүүс байгууллагын тайлан, ярилцлагаар харьцуулан баримтжуулж болох юм.
4. Мөн уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой агаар бохирдсон тохиолдолд агаарын бохирдлын хэмжигч багажаар хэмжиж тодорхойлох замаар баримтжуулалтаа баяжуулаарай.

2. Эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл:

№	Олборлолт явагдаж буй газарт нутагт амьдарч буй иргэдийн, ялангуяа хүүхэд эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд уурхайгаас шалтгаалсан ямар нэг эрүүл мэндийн сөрөг нөлөө үүссэн үү?	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1.	Уушигны шохойжилт			
2.	Нөхөн үржихүйн эрүүл мэндтэй холбоотой өвчлөл			
3.	Цацраг идэвхт бодисын хордлого			
4.	Амьсгалын замын өвчин			
5.	Арьс загатнах, аллерги өгөх			
6.	Нүдний өвчлөл			
7.	Бусад:			
Эрүүл мэндийн үйлчилгээ, асаргаатай холбоотой асуулт				
1.	Компани болон засгийн газраас тухайн газар нутагт амьдарч буй иргэдийн дунд эрүүл мэндийн тогтмол үзлэг зохион байгуулдаг уу?			
2.	Уурхайгаас үүдсэн эрүүл мэндийн асуудалд эмэгтэйчүүдэд компани болон засгийн газраас ямар нэгэн нөхөн төлбөр өгсөн үү?			
3.	Уул уурхайгаас үүдэлтэй хол нүүснээс болж жирэмсэн болон нярайн хяналтандаа орж чадахгүй хоцрох явдал гарч байсан уу?			

Жич: Эрүүл мэндтэй холбоотой сөрөг нөлөөлөл гарсан талаар тухайн орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд ярилцлага, асуулгаар илэрхийлсэн бол дараах нэмэлт баримтжуулалтуудыг мөн хийх шаардлагатай. Үүнд:

1. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой шохойжилт, амьсгалын замын өвчлөл, нүдний өвчлөл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал ихэссэн бол энэ талаарх шинжилгээний баримт, тухайн сум орон нутгийн эмнэлгийн байгууллагаас хийсэн судалгаа, статистикийн нэгтгэл, орон нутгийн эмчийн ярилцлага
2. Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хөрс, усны бохирдол, химийн бодисын аюулгүй ажиллагааны алдагдлаас үүдэлтэй ямар нэг арьсны өвчлөл, харшил аллергены асуудал байгаа талаар орон нутгийн иргэд, эмэгтэйчүүд асуулга ярилцлагын үеэр дурдсан бол арьсан дээр харшилын зургийг тухайн оршин суугчийн зөвшөөрөлтэйгээр авч баримтжуулан хавсаргаж болно. Түүнчлэн, харшлын эсрэг тест өгч юунаас харшил үүссэн талаарх баримтыг ч бас хавсаргаж болох юм.
3. Уул уурхайн олборлолт явуулж буй компаниуд ямар төрлийн химийн бодисыг ямар хэмжээгээр хэрэглэж байгаа тайланг Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын www.e-reporting.eitimonqolia.mn болон Байгаль орчны мэдээллийн сангийн <https://eic.mn/> сайтаас авч, хянаж, үнэлгээндээ хавсаргаарай.

3. Нийгэм – соёлын нөлөөлөл

№	Танай орон нутагт нийгмийн дараах үр нөлөөнүүд гарсан уу?	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1.	Шилжин суурьшилт ихэссэн			
2.	Гэр бүлийн хүчирхийлэл нэмэгдсэн			
3.	Амиа хорлолт нэмэгдсэн			
4.	ХДХВ/ДОХ болон БЗДХ ихэссэн			
5.	Мансууруулах бодисын хэрэглээ ихэссэн			
6.	Архидалт ихэссэн			
7.	Биеэ үнэлэлт (Ялангуяа насанд хүрээгүй охидын дунд) нэмэгдсэн			
8.	Хүчингийн гэмт хэргийн тоо өссөн			
9.	Хүүхдийн хөдөлмөр (газар, малаа алдсанаас болж ядуурснаас эцэг эхчүүд хүүхдээрээ хөдөлмөр эрхлүүлэхэд хүрэх)			
10.	Малын ноос түүхий эдийг боловсруулж борлуулахад сөргөөр нөлөөлөх			
11.	Жилийн дөрвөн улиралд нүүдэл хийх газаргүй болох			
12.	Хадлан өвс тэжээл авах, оторлох газар нутаггүй болох			
13.	Хурдан морь уях, наадам арга хэмжээ зохион байгуулах газаргүй болох			

14.	Малын үүлдэр угсаа авч үлдэх, өвлүүлэхэд хүндрэлтэй болох			
15.	Өвөг дээдсээс идээшиж дассан нутагтаа үргэлжлүүлэн амьдрахад хүндрэлтэй болох			
16.	Овоо тахилгаа шүтэх, тахиx, хөндөхгүй байх заншил зөрчигдөх			
17.	Ихсийн газар ариун дагшин байх, үр хүүхэд хойч үе сайн сайхан явах итгэл үнэмшил алдагдахад			
18.	Ус рашаанаа ашиглах, хамгаалж чадахгүйд хүрэх			
19.	Малын сүү цагаан идээгээ боловсруулахад болон худалдан борлуулж чадахгүйд хүрэх			
20.	Уул уурхайгаас үүдэлтэй хол нүүснээс болж хүүхдүүд сургууль, цэцэрлэгтээ явж чадахгүйд хүрэх			
21.	Та явганаар ус авахаа болиод холоос мотоциклоос ус авдаг болох			
22.	Малын ус багассанаас худал дээр малаа услах цаг нэмэгдсэн үү?			
23.	Ундны уснаас холдсоноор хүний хараат (машин, мотоциклгүйн улмаас хүнээс гуйх, компанийн хүргэлтийн усыг хүлээх гэх мэт) байдалд орсон уу?			
24.	Тоос шороо нэмэгдсэнээс гэр орны цэвэрлэгээний ажил ихэссэн үү?			
25.	Бусад			

Жич: Нийгэм-соёлын нөлөөлөл нь тухайн орон нутгийн амьдралын хэв маяг, түүх соёл, итгэл үнэмшилтэй холбоотой олон асуудлыг өргөн хүрээнд хамарсан чухал ойлголт байдаг билээ. Тиймээс уул уурхайн шууд болон шууд бус нөлөөллийн бүсэд амьдарч буй орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдээс ярилцлага, асуулгын үеэр илэрхийлсэн нийгэм, соёлын эрхийн зөрчлийг дараах нэмэлт мэдээлэл цуглуулах байдлаар баримтжуулж баталгаажуулах шаардлагатай. Үүнд:

1. Тухайн орон нутагт уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой нийгмийн сөрөг үйлдлүүдийн (архидалт мансууруулах бодисын хэрэглээ, зодоон танхай, гэр бүлийн хүчирхийлэл, хүчингийн гэмт хэрэг, амиа хорлолт, осол аваар) талаарх мэдээллийг орон нутгийн цагдаагийн байгууллагаас, эмнэлгийн байгууллагаас (хүчингийн гэмт хэрэг, биеэ үнэлэлт, гэр бүлийн хүчирхийлэл, ХДХВ/ДОХБЗДХ өвчлөл ихэссэн талаарх статистик мэдээллийг) авч болно.
2. Нүүдэллэх газаргүй болж, нутаг орноосоо шахагдан нүүх, өвөг дээдсийн онгон дагшин газартаа очих боломжгүй болж уул уурхайн компанид булаалгах, хадлан өвс тэжээлээ хураах газаргүй бол хавчигдаж байгаа талаарх мэдээллийг фото зураг болон нийгмийн зураглал хийх аргаар давхар баримтжуулах боломжтой.
3. Иргэдийн мал аж ахуй, газар тариалангаас олдог байсан орлого нь уул уурхайн үйл ажиллагаанаас болж хэрхэн буурч, алга болж байгаа талаарх мэдээллийг кэйс түүх, болон ярилцлагын аргаар дэлгэрэнгүй баримтжуулаарай.

4. Уул уурхайтай бүс нутгийн малын үнэ ханшийг бусадтай харьцуулан дүгнэх. Тухайлбал бусад уурхай байхгүй сумдын малын махтай харьцуулахад танай сум, багийн малын махны үнэ, ноос ноолуур бусад түүхий эдийн үнэ ямар байгааг харьцуулж судлаарай.

III. Уурхайг хаах төлөвлөгөө, Компанийн амлалт,

1. Олборлолт дууссаны дараа байгаль орчны нөхөн сэргээлт, уурхайг хаахтай холбоотой ямар нэг мэдээллийг компани та бүхэнд өгсөн үү? Энэ талаар танилцуулга мэдээлэл өгсөн үү?
- o Тийм
 - o Үгүй
 - o Би энэ талаар мэдэхгүй байна
2. Компани үйл ажиллагаа явуулж эхлэхийн өмнө орон нутгийн иргэдэд дараах амлалтуудаас алийг нь өгсөн бэ? (хэдэн ч хариулт сонгон, дугуйлж болно)
- o Ажлын байр (эрэгтэй, эмэгтэйчүүдэд зориулсан) нэмэгдүүлэх
 - o Сургууль, цэцэрлэг барих
 - o Эрүүл мэндийн төв байгуулах
 - o Худаг гаргаж өгөх
 - o Орон нутгийн төсөвт мөнгөн хандив өгөх
 - o Баяр ёслолын үеэр малчдад бэлэг тараах
 - o Малчдад оюутны сургалтын төлбөрийг төлж өгөх
 - o Бусад
3. Компани олсон ашиг эсвэл ногдол ашгаас ямар нэг орлого өгнө гэж амласан уу?
- o Тийм
 - o Үгүй
 - o Би энэ талаар мэдэхгүй байна
4. Энэ олборлох төслөөс та ямар нэг ашиг хүртэнэ гэж бодсон уу?
- o Тийм
 - o Үгүй
 - o Би энэ талаар мэдэхгүй байна

Олборлолт дууссаны дараа тухайн орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдийн амьдралд ямар эерэг өөрчлөлт бий болсон байх талаар хаалтын төлөвлөгөөнд туссан уу? Үүн дээр газрын нөхөн сэргэлтээс гадна тухайн орон нутгийн иргэдийн амьдралд гарах өөрчлөлтийг урьдчилан тооцоолж, уурхай хаагдахад аж амьдрал хэвийн явагдах, ирээдүйн амьдралын баталгааг хангах тал дээр хийх ажил, зарцуулах санхүүжилтийг хаалтын төлөвлөгөөнд тусгасан уу?

Дэлгэрүүлж мэдээлэл авахдаа дараах бүлгийн болон ганцаарчилсан ярилцлагын асуултуудыг ашиглаарай

Олборлолт явуулах зөвшөөрөл авсан үйл явцыг үнэлэхдээ өмнөх бүлэгт буюу “Олборлолтын өмнөх үе шаг”-нд хэрэглэж байсан ярилцлагын асуултуудыг ашиглаарай.

Эмэгтэйчүүдэд олборлох уурхайгаас гарах үр дагавар\үр нөлөөг урьдчилсан байдлаар тооцоолох, эмэгтэйчүүдэд тулгарсан үр нөлөөг ЖҮНҮ тусламжтайгаар үнэлэхэд ашиглаж болох ярилцлагын асуултууд:

- Танай орон нутагт эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэрийн ажил үүргийн хуваарь юу вэ?
 - a. Олборлох уурхайн төсөл эхэлснээс хойш энэ ажил үүрэгт ямар нэг өөрчлөлт орсон уу? (аль нэг нь гэрийн ажлыг хийхэд илүү олон цаг зарцуулах болсон, эрэгтэй, эмэгтэйчүүдийн эсвэл гэр бүлийн гишүүдийн гэрийн ажил дахь үүрэг солигдох гэх мэт)
- Танай гэр бүл ямар нэг газар эзэмшиж / өмчилдөг үү? Тийм бол хэний нэр дээр байдаг вэ? Албан ёсны бүртгэл хийлгэж гэрчилгээ авсан уу? Ямар хугацаатай гэрээ эсвэл өмчлөх эрхтэй вэ?
- Та уул уурхайн үйл ажиллагааны үр дагавар\үр нөлөөгөөр эзэмшил / өмчлөлийн газраа алдсан уу? Хэрэв тийм бол:
 - b. Таныг болон танай гэр бүлийг хүчээр танай эзэмшлийн газарт, эсвэл эцэг эхээс уламжлан ирсэн өвөлжөө, хаваржаа, малын бэлчээрээс нүүлгэсэн үү?
 - c. Үүнийхээ төлөө ямар нэгэн нөхөн төлбөр, нөхөн сэргээлт хийсэн үү? Хэрэв тийм бол:
 - i. Газрын нөхөн төлбөрт өгсөн мөнгөний хэмжээ юм уу, шинээр ямар газар өгсөн бэ? Та сэтгэл хангалуун үлдэж чадсан уу?
 - ii. Нөхөн төлбөр болон нөхөн сэргээх үйлчилгээг ямар хугацаанд үзүүлсэн бэ?
 - iii. Нөхөн төлбөрөө авах хооронд танд ямар нэг асуудал тулгарсан уу?
 - iv. Хэрэв таны газрын оронд өөр газар өгсөн бол, тэр газар танай гэр бүлийнхний хамтын эзэмшилд (өрхийн тэргүүн болон эхнэрийн нэр дээр) очсон уу?
 - v. Танай газар болон хөрөнгийн үнэлгээг хэрхэн тогтоосон, шударга байж чадсан гэж та үздэг үү?

- d. Ингэж газраа алдсанаар танд ямар сөрөг нөлөө гарсан, амьдралын чанарт ямар өөрчлөлт орсон бэ?
- e. Шинээр буусан газар нь хуучин өвөлжөө, хаваржааны газраас чанар, өгөөжийн хувьд дээрдсэн үү эсвэл дордсон уу?
- Та уурхайгаас болж орон байрнаасаа нүүх шаардлагатай болсон уу? Хэрэв тийм бол,
 - f. Танд ямар нэг нөхөн төлбөр өгсөн үү? Хэрэв тийм бол,
 - i. Газрын нөхөн төлбөрт өгсөн мөнгөний хэмжээ, шинээр ямар газар өгсөн бэ? Та сэтгэл хангалуун үлдэж чадсан уу?
 - ii. Нөхөн төлбөр болон нөхөн сэргээх үйлчилгээг ямар хугацаанд, ямар хэлбэрээр үзүүлсэн бэ?
 - iii. Нөхөн төлбөрөө авах хооронд танд ямар нэг асуудал тулгарсан уу?
 - g. Энэ өөрчлөлт таны өдөр тутмын амьдралд ямар нөлөө үзүүлсэн бэ?
 - h. Нөхөн төлбөртэй холбоотой үүссэн гомдлоо хаана гаргасан бэ? Хэрхэн шийдвэрлэгдсэн бэ?
- Нөхөн төлбөр болон нөхөн сэргээх үйл ажиллагаатай холбоотой ямар нэг маргаантай тохиолдол/кейс байсан уу? Эдгээр тохиолдол, кейсүүд яаж шийдвэрлэгдсэн бэ?
- Энэ олборлолтын төсөл эхлэхээс өмнө таны орлого олдог гол эх үүсвэр юу байсан бэ? (газар тариалан, тахиа шувууны аж ахуй, мал аж ахуй гэх мэт)
 - i. Олборлолт эхэлснээс хойш таны орлого, амьдралын чанар энэ үйл явцад ямар өөрчлөлт гарсан бэ?
 - j. Олборлолт эхэлснээс хойш, таны олдог орлого нэмэгдсэн үү эсвэл буурсан уу?
- Олборлолт эхэлснээс хойш танай орон нутагт замтай холбоотой шинэ асуудлууд үүссэн үү? Жишээ нь тоосжилт, хэт олон машин зорчих, бэлчээрээр замгүй газраар машин явах, хүний хөл хөдөлгөөн нэмэгдэх гэх мэт. Үүний үр дүнд ямар өөрчлөлтүүд гарсан бэ? Ямар нэгэн аваар осол гарсан уу?
- Бэлгийн дарамт зэргээс үүдэж эмэгтэйчүүд ганцаараа явахаас, окидуудаа ганцаар явуулахаас санаа зовох зэрэг байдал гардаг болсон уу? Эрх толгойлсон, эсвэл нөхөргүй эмэгтэйчүүдэд бэлгийн дарамт ирэх, айдастай байх байдал нэмэгдсэн үү?
- Нутгийн иргэд үнэ цэнэгүй болох, үл тоогдох асуудал гарч байна уу?
- Уурхайд эхнэр, нөхрийн аль нэг нь ажилд орсноос болж, эсвэл уурхайн үйл ажиллагаанаас болж орлогоо алдсанаас үүдэн эхнэр/нөхрийн аль нэг нь өөр

газарт очиж ажиллах гэх мэт гэр бүл хуваагдаж амьдрах асуудал гарч байна уу?

- Уламжлалт ахуйд өөрчлөлт орох, хоолны газар, буудлын тоо хэт өсөх, зугаа цэнгээн шоу арга хэмжээ олшрох, гаднын хүний тоо өсөх
- Нутгийн иргэд олон судалгаанд хамрагдах, залхах улмаар аль нь чухал чухал бусыг ялгахгүй болж уйдах, улмаар мэдээлэл өгснийхөө төлөө төлбөр нэхэх
- Уурхайг дагасан шилжин суурьшилт ихэссэнээр боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний чанар муудсан.

ХОЁРДУГААР ХЭСЭГ

Олборлох уурхайн компанид ажиллаж буй орон нутгийн эмэгтэйчүүдээс асуух асуулга

I. Ерөнхий мэдээлэл:

1. Байршил: (олборлолт хийж буй газар):
 2. Уурхайн компанийн нэр:
 3. Олборлолтын төрөл:
 4. Санхүүжилт, хөрөнгө оруулалт нь хаанаас вэ?
 5. Асуулга авч буй огноо: 20. . оны . . сарын . . өдөр
1. Та энэ компанид ажилд орохын өмнө ямар нэг ажил хийж байсан уу?
 - Тийм бол, та ямар ажил хийдэг байсан бэ?
 - Үгүй
 2. Та энэ уурхайн компанид ажилд ороход юу нөлөөлсөн бэ?
 - Цалин мөнгө
 - Байршил
 - Компаниас өгдөг бусад хангамжууд
 - Бусад
 3. Компанид хийж буй таны ажил байнгын, улирал тутмын аль нь вэ?
 - Байнгын (жилийн 4 улирал ажилладаг)
 - Улирлын шинжтэй (зөвхөн дулааны улиралд ажилладаг)
 - Гэрээт (гэрээгээр үе үе ажилладаг)
 - Бусад
 4. Компани уурхайн олборлолтын үйл ажиллагаа эхлэхээс өмнө санал болгож байсан ажилдаа таныг авсан уу?
 - Тийм
 - Үгүй, анх санал болгож байсан ажлын байр яаж өөрчлөгдсөн бэ?
.....

5. Дараах асуултуудад хариулна уу?

№	Асуултууд	Тийм	Үгүй	Мэдэхгүй
1.	Уул уурхайн компанид ажилд орсноор орон нутгийн иргэдээс дарамт шахалт үзүүлэх, нэр хоч өгөх асуудал гарсан уу?			
2.	Та ажилд орох үедээ ямар нэг ялгаварлан гаруурхалтад (эмэгтэй гэдгээсээ болж, орон нутгийн иргэн гэдгээсээ болж, мэдлэг мэдээлэлгүйгээсээ болж гэх мэт) өртөж байсан уу?			
3.	Та эрэгтэйчүүдтэй адил хэмжээний цалин авч байгаа юу?			
4.	Та илүү цагаар ажилласан үедээ илүү цагийн мөнгө авдаг уу?			
5.	Та ээлжээр ажиллах шаардлагатай болдог уу?			
6.	Компани таныг ямар нэг сургалтад хамруулсан уу?			
7.	Та, компанид ямар нэг бэлгийн дарамтаас хамгаалах бодлого байдаг эсэх талаар мэдэх үү?			
8.	Энэ ажлаас болж таны эрүүл мэндэд ямар нэг сөрөг өөрчлөлт гарсан уу?			
9.	Ажлын байран дээрээ гэмтэж бэртсэн тохиолдолд компанийн зүгээс танд нөхөн төлбөр олгож байсан уу?			
10.	Та хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг уу?			

Дэлгэрүүлж асууж болох ярилцлагын асуултууд

- Таны одоогийн хийж байгаа ажил:
 - Ажиллах цагийн хувьд
 - Долоо хоногт ажиллах өдрийн хувьд
 - Энэ ажлыг хийж эхэлснээс хойш таны амьдралын чанар дээшилсэн үү?
- Та энэ компанид хөдөлмөрийн гэрээтэй ажилладаг уу? Эсвэл түр ажлын байр уу? Хэрэв тийм бол гэрээний хугацаа ямар вэ?
- Таны хувь хүний хөгжил энэ компанид ямар байгаа гэж та боддог вэ? Таныг карьераа өсгөхөд компани дэмжлэг үзүүлдэг үү?
- Та компанид ажиллах хугацаандаа ямар нэгэн бэлгийн дарамттай учирч байсан уу? Хэн нэгэнд мэдэгдсэн үү? Хэрэв тийм бол, та юу хийсэн бэ? Энэ талаар компанийн авсан арга хэмжээ авсан уу, та сэтгэл хангалуун байгаа юу?
- Компанид эмэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах ямар нэг хороо юм уу? эсвэл үйлдвэрчний эвлэлийн төлөөлөгч байгаа юу?
- Та компанийн менежменттэй холбоотой санал бодлоо хэлэх суваг юу вэ?
- Компанийн менежменттэй холбоотой өөрийн санал бодлоо илэрхийлж байсан таны туршлага юу вэ?

8. Ажлаа хийхэд шаардагдах хооллох газар, ариун цэврийн өрөө, амрах өрөө, хүүхэд асрах өрөө, ажил руугаа хүрэх тээврийн хэрэгсэл гээд дэд бүтцээр таныг хангалттай хангадаг байсан уу?
9. Жирэмсэн эмэгтэйчүүд ямар төрлийн жирэмсний тэтгэмжүүд авах боломжтой байдаг вэ?
10. Танай гэр бүл орон байр, боловсрол, эрүүл мэнд болон даатгалын ямар тэтгэмж авч байсан бэ?
11. Хөдөлмөр хамгааллын хувцас, маск гэх мэт ямар хэрэгслүүдээр компани таныг хангадаг вэ?
12. Та, танай орон нутгаас ажилд орсон эмэгтэйчүүдээс ажлаасаа халагдсан ямар нэг тохиолдол мэдэх үү? Хэрэв тийм бол ямар шалтгааны улмаас ажлаасаа халагдсан бэ?
13. Ямар тэтгэврийн тэтгэмжийг компани санал болгодог бэ?
14. Компани ХДХВ/ДОХ-с урьдчилан сэргийлж, хамгаалах талаар ямар бодлого баримталдаг вэ?
15. Уурхайг хаах төлөвлөгөөний талаар компани танд юу хэлсэн бэ?
16. Хэрэв уурхай хаагдсан тохиолдолд таны орлого нэмэгдүүлэх ямар арга замуудыг компани санал болгосон бэ?
17. Компани хаагдахын өмнөх амласан нөхөн төлбөр нь хэд/юу байсан бэ?
18. Та ажлын байран дээрээ аюултай байгаа юм шиг мэдэрч байсан удаа бий юу? Хэрэв тийм бол ямар шалтгаанаар вэ?

I. Компанийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Компанийн албан ёсны нэр, нутгийнхны дунд нэршсэн нэр	
Яг одоо олборлолт хийж буй байршил	
Олборлолтын үйл явц: эрэл, хайгуул, ашиглалт, хаалт, баяжуулах, боловсруулах алин болох	
Хэрэв олон улсын компани бол бүртгэл нь хаана байдаг	
Та ээлжээр ажиллах шаардлагатай болдог уу?	

II. Ажилтны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл

Тоо бичих	Удирдлагын түвшинд		Ажилчны түвшинд		Бүгд	
	Байнгын	Гэрээт	Байнгын	Гэрээт	Байнгын	Гэрээт
Эрэгтэй						
Эмэгтэй						

III. Эмэгтэй ажилтнуудын албан тушаалын талаарх мэдээлэл

Хэлтэс/нэгж/процесс/ Үйл ажиллагаа*-ны нэр	Ажилтны албан түвшин**

**Эдгээр нь хэлтэс/нэгж/процесс/үйл ажиллагаан дахь албан тушаалын түвшин юм. Доорх зайд ямар албан тушаалын түвшин байдгийг жагсаан бичнэ үү.
Жишээ нь: Үйлчлэгч, тогооч, Том машины жолооч, дэлбэлэгч, хүний нөөцийн хэлтэс, аюулгүй ажиллагааны ажилтан, харуул (гэр бүлээрээ хийдэг), захиргааны ажилтан, менежер гэх мэт

IV. Эмэгтэй ажилтнуудын:

- A. Тухайн орон нутгаас ажилд орсон эмэгтэйчүүдийн тоо, ажиллаж байгаа албан тушаал, одоогийн байдлаар –
- B. Өөр орон нутгаас ажилд орсон эмэгтэйчүүдийн тоо, ажиллаж байгаа албан тушаал, одоогийн байдлаар –

V. Компанийн бодлого

Ажилд авах, ажлаас цомхотгох бодлого

1. Компанийн ажилд авах, ялангуяа эмэгтэйчүүдийг ажилд явах бодлого нь юу вэ?
Гол бодлогуудаас дурдана уу?
2. Ажилд авахдаа компани жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангадаг вэ?
3. Орон нутгийн эмэгтэйчүүд ихэвчлэн ямар ажлын байр, албан тушаалд ордог вэ?
Та бүхний мэдлэг, ур чадварыг шударга үнэлдэг үү.
4. Орон нутгийн эмэгтэйчүүд болон гаднаас ирж ажиллаж буй эмэгтэйчүүд хооронд ажлын байр бусад цагийн нөхцөл ялгаа байдаг уу?
5. Компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш сүүлийн 5 жилд удирдлагын түвшинд эрэгтэйчүүдтэй харьцуулахад хичээн эмэгтэйг ажилд авсан бэ?
6. Компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш сүүлийн 5 жилд ажилчны түвшинд эрэгтэйчүүдтэй харьцуулахад хичээн эмэгтэйг ажилд авсан бэ?
7. Компани ажилтнуудынхаа тоог багасгасан удаа бий юу? (тийм/үгүй) хэрэв тийм бол,
 - a. Цомхотголд орсон эрэгтэй ажилтнуудын тоо
 - b. Цомхотголд орсон эмэгтэй ажилтнуудын тоо
8. Цомхотголд орсон эмэгтэйчүүдэд өгсөн халагдсаны тэтгэмж нь юу байсан бэ?
9. Эдгээр эмэгтэйчүүдийг өөр ажилд ороход нь ямар дэмжлэг, туслалцаа үзүүлсэн бэ?
10. Цомхотгол хийх үеэр ажилтнуудад хэд хоногийн өмнө ямар хэлбэрээр мэдэгддэг, харилцах харилцаа нь ямар байсан бэ? өмнөхтэйгээ адилхан байсан уу?
11. Цомхотгол хийх үйл явц дахь эмэгтэйчүүдийн хороо, үйлдвэрчний эвлэлийн үүрэг оролцоо ямар байсан бэ?

Урамшууллын бодлого

1. Эмэгтэйчүүд адилхан ажил хийгээд эрэгтэйчүүдийн адил цалин авдаг уу?
2. Эмэгтэйчүүд илүү цагаар ажиллавал илүү цагийн хөлс яаж олгодог вэ?
3. Эмэгтэйчүүд хөдөлмөрийн хөлстэй холбоотой маргаан үүсгэх, шийдвэрлэх ойлгомжтой бүтэц байдаг уу

Сургалтын бодлого

1. Сургалтад хамрагдахад эмэгтэйчүүдийн эзлэх хувь ямар байдаг вэ?
2. Эмэгтэйчүүдэд зориулан хэдэн удаагийн сургалт явуулсан бэ? (сургалтын календарьчилсан төлөвлөгөөг хавсаргах)
3. Эдгээр сургалтууд нь үйлчилгээний ажил хийдэг эмэгтэйчүүд компани дотроо түвшин ахисан ажил хийхэд туслах ур чадваруудыг өгсөн үү?
4. Эмэгтэйчүүдэд зориулсан тусгай болон захиалгын сургалт нь эмэгтэйчүүдийг техникийн салбарт ажиллах боломжтой болгоход тусалсан уу?
5. Эдгээр сургалтууд нь эмэгтэйчүүдийг тушаал дэвшихэд дэмжлэг үзүүлсэн үү?
6. Эмэгтэйчүүдийг мэдлэг ур, чадвараа дээшлүүлэх зорилгоор компаниас гадуурх сургалтад хамруулсан уу?
7. Гамшгийн үеийн менежментийн сургалтад эмэгтэйчүүдийг хамруулсан уу?

Ажлын цаг

1. Өдөрт эмэгтэйчүүд хэдэн цаг ажиллах ёстой байдаг вэ?
2. Долоо хоногийн хэдэн өдөрт эмэгтэйчүүд ажиллах ёстой байдаг вэ?
3. Эмэгтэйчүүд ээлжээр ажилладаг уу? хэрэв тийм бол, ямар ээлжээр ажилладаг бэ? (24/72, 24/48 гэх мэт)
4. Шөнийн ээлжид ажилладаг эмэгтэйчүүдийг компаниас ямар төрлийн хангамжаар хангадаг вэ? Жишээ нь гэрээс нь авч, хүргэж өгөх, ажлын байр дээр аюулгүй байдлыг хангах гэх мэт
5. Орон нутгийн эмэгтэйчүүд гэрээсээ уурхайн кемп хүртэл хэдэн цаг явж ирдэг очдог вэ Нийт хэдэн цаг, замын асуудлыг шийдсэн үү

Бэлгийн дарамтаас хамгаалах бодлого

1. Компанид бэлгийн дарамтаас хамгаалах бодлого байдаг уу?
2. Энэ бодлогыг компани ажилтнууддаа хэрхэн танилцуулдаг вэ? (тэмдэглэлээр, ажилд урьсан захидал дотроо оруулсан байдаг гэх мэт)
3. Бэлгийн дарамтын хохирогч эмэгтэй хэнд хандаж өргөдөл, гомдлоо гаргах ёстой байдаг вэ?
4. Бэлгийн дарамтын өргөдөл гомдлыг яаж хүлээн авдаг вэ?
5. Танай компанид бэлгийн дарамттай холбоотой гарсан тохиолдлыг магадлан шалгах хороо байдаг уу?

6. Тэр хороог эмэгтэй хүн удирддаг уу?
7. Тэр хороонд хэдэн эмэгтэй гишүүн байдаг вэ?
8. Өргөдөл гомдол хүлээн авснаас хойш шийдвэрлэх хүртэл ямар хугацаатай байдаг вэ?
9. Өргөдөл гомдлыг хүлээн авснаас хойш ямар алхмууд хийгддэг вэ?
10. Ажилтнуудад бэлгийн дарамтаас хамгаалах бодлогыг танилцуулсан ямар сургалт байдаг вэ?
11. Танай компанид эмэгтэйчүүдэд бэлгийн дарамт үзүүлсэн тохиолдол байгаа юу? Хэрэв тийм бол ямар арга хэмжээ авсан бэ?
12. Хэрвээ бэлгийн дарамт үзүүлсэн этгээд буруутай гэдэг нь тогтоогдвол компанийн зүгээс ямар хариуцлага тооцдог вэ? ямар арга хэмжээ авдаг вэ?

ХДХВ/ДОХ-ын талаарх бодлого

1. Ажилд орсон, орох гэж байгаа хүмүүс өөрийнхөө ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээллийг компанид өгөх ёстой байдаг уу?
2. Ажилд орохын өмнө урьдчилсан эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ хийдэг үү?
3. Одоогийн ажиллаж байгаа ажилтнуудаа эрүүл мэндийн үзлэгт хамруулж, ХДХВ/ДОХ-ын халдвар авсан эсэхийг тогтмол хянадаг уу?
4. Мэдээллийн нууцлал хэр хадгалагддаг вэ хэр найдвартай вэ Үүнээс болж ялгаварлан гадуурхалт байдаг уу?
5. Ажилтнуудад зориулсан сайн дурын үзлэг, шинжилгээнд орох төхөөрөмж, хэрэгсэл байдаг уу? Энэ тохиолдолд шинжилгээний үр дүнг үзэх эрх компанид байдаг уу? Ажилтан өөрийн халдвартай эсэх мэдээллээ илчлэх шаардлагатай байдаг уу?
6. Хэрэв тухайн ажилтан ХДХВ/ДОХ-ын халдвартай гэдэг нь ажилтан өөрөө хэлээгүй байхад бусад эх сурвалжаас удирдлагад нь илчлэгдвэл түүний дараа юу болох вэ?
7. ХДХВ/ДОХ-ын халдвартай ажилтан удирдлагаасаа хэрхэн туслалцаа авах вэ?
8. ХДХВ/ДОХ-ын халдвартай ажилтнуудтай ажиллах ур чадварыг удирдлагад олгох ямар сургалт байдаг вэ?
9. Хэрэв ажилтан нь ХДХВ/ДОХ-ын халдвартай гэдгийг мэдчихвэл удирдлага ямар алхмууд хийх вэ?
10. ХДХВ/ДОХ-ын халдвартай өвчтөнд сэтгэл зүйн болоод эрүүл мэндийн ямар тусламж, дэмжлэг компанийн зүгээс үзүүлдэг вэ? Халдвар авсан ажилтнуудад зориулсан ямар эмчилгээний хөтөлбөрийг компаниас үзүүлдэг вэ? Хэчнээн хүн энэ хөтөлбөрт бүртгэлтэй байдаг вэ?
11. ХДХВ/ДОХ-ын халдвартай ажилтан хэзээг хүртэл ажлаа хийхийг зөвшөөрдөг вэ?
12. Хэрэв ХДХВ/ДОХ-ын халдвартай ажилтан өөрийн ажлаа хийж чадахгүйд хүрвэл компанийн зүгээс өөр ажил санал болгодог уу?

13. Хэрэв тэд ямар ч ажил хийх боломжгүй болсон үед ямар тэтгэвэр, эрүүл мэндийн тэтгэмжээр хангадаг вэ?
14. Ажилтан нас барсны дараа түүний халдвартай байсан талаарх мэдээлэл ил болгодог уу?
15. Компани нийт ажилтнуудынхаа дунд ХДХВ/ДОХ-ын халдвар авахаас урьдчилан сэргийлэх мэдлэг олгох ямар кампанит ажил, үйл ажиллагаа хэрэгжүүлдэг вэ?
16. ХДХВ/ДОХ-ын талаарх мэдээллийг ажилтнууд хаанаас, хэрхэн авах боломжтой вэ?
17. Танай компани ХДХВ/ДОХ-ын талаар баримтлах бодлоготой юу? Өнөөг хүртэл хэчнээн ХДХВ/ДОХ-ын халдварын тохиолдол танай ажилтнуудаас бүртгэгддээ байна вэ? тэдний хэд нь эмэгтэй, хэд нь эрэгтэй вэ?
18. Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагаас ажиллах хүчинд зориулан гаргасан ХДХВ/ДОХ-ын бодлогын талаар та мэдэх үү?

Ажиллах орчин

1. Эмэгтэй ажилчид ажил дээрээ ямар хөдөлмөрийн хэрэгсэл ашигладаг вэ?
2. Эмэгтэйчүүдэд зориулсан хөдөлмөрийн тусдаа хэрэгсэл байдаг уу?
3. Ажлын байран дээрээ эмэгтэйчүүд ямар аюулгүйн тоног төхөөрөмж, ажлын хувцсаар хангагддаг вэ?
4. Ялгаа бүхий ажлын ямар нэгжүүд байдаг вэ? тэдний аль нь аюултай байдаг вэ?
5. Ямар төрлийн ажил/нэгжийг хийхийг эмэгтэйчүүдэд хориглодог вэ?
6. Эмэгтэй ажилтнуудад зориулсан нислэгийн үеэр баримтлах ямар дүрэм байдаг вэ? Нислэгийн үеэр эмэгтэйчүүд тусгай үйлчилгээ, хангамжаар хангагддаг уу?
7. Эмэгтэйчүүд ажлын байран дээрээ гэмтсэн тохиолдолд ямар нөхөн төлбөр, нөхөн сэргээх үйлчилгээ, даатгал үйлчилдэг вэ?
8. Эмэгтэйчүүдийн ажиллах орчин: агааржуулалт салхивч, гэрэлтэй эсэх, 00 эрэгтэй тусдаа, угаалгын өрөө байгаа эсэх г м

Эмэгтэйчүүдийн төлөөлөл

1. Компанийн зөвлөл, үйлдвэрчний эвлэлд эмэгтэйчүүдийн төлөөллийг хэрхэн хангадаг вэ?
2. Эмэгтэйчүүдийн эзлэх хувь хэд вэ?
3. Энэхүү зөвлөл, үйлдвэрчний эвлэлд эмэгтэйчүүдийн оролцох үүрэг роль ямар вэ?
4. Зөвлөл/үйлдвэрчний эвлэл ямар эрх мэдэлтэй вэ?
5. Аюулгүй ажиллагааны нөхцөлийг баталгаажуулж, хангахад туслах аюулгүйн зөвлөлд эмэгтэйчүүдийн эзлэх төлөөлөл ямар байдаг вэ?

Дэд бүтэц

1. Эмэгтэйчүүдэд зориулсан ямар төрлийн хангамж/үйлчилгээ байдаг вэ?
 - a. Амралтын өрөө №
 - b. Хоолны газар №
 - c. Ариун цэврийн өрөө №
 - d. Хүүхэд саатуулах газар №
2. Эмэгтэйчүүд ажлын байрандаа хүргүүлэх ямар нэг тээврийн хэрэгсэл байдаг уу? Тээврийн замын асуудал хэрхэн шийдэж чадсан эсэх: шороон зам, сайжруулсан эсэх, асфальтан зам гэх мэт

Тэтгэмж

1. Жирэмсний ямар тэтгэмж өгдөг вэ?
2. Шинэ аавын чөлөөг эрэгтэйчүүдэд олгодог уу?
3. Аюултай, хортой химийн бодистой харьцах ажил хийдэг эмэгтэйчүүд жирэмсэн байх үед болон хүүхэд нь нялх байх хугацаанд хор, аюулгүй өөр ажил орлуулан хийдэг үү?
4. Эмэгтэйчүүдэд, тэдний гэр бүлд зориулсан ямар эрүүл мэнд, орон байр, боловсролын үйлчилгээг компаниас хангадаг вэ?
5. Ямар төрлийн тэтгэврийн тэтгэмжээр эмэгтэйчүүдийг хангадаг вэ?

Эрүүл мэнд

1. Аюултай, хортой ажил хийж буй эмэгтэйчүүдэд тэдний эрүүл мэндэд учрах сөрөг нөлөөллийн талаар мэдээлдэг үү?
2. Компани нь уурхай хаагдах үеийн эмэгтэйчүүдийн хөдөлмөрт үзүүлэх нийгэм, эдийн засгийн үр нөлөөг үнэлсэн үү? Ямар үр нөлөөнүүд гарч болох вэ?
3. Эмэгтэйчүүдэд зориулсан нөхөн төлбөрийн ямар багц байдаг вэ?
4. Уурхайн хаагдсаны дараа эмэгтэйчүүдийн амьжиргаанд дэмжлэг үзүүлэх өөр үйл ажиллагааны ямар төлөвлөгөө байгаа вэ?

Дэд гэрээгээр гүйцэтгэх ажил

1. Компани ямар нэг гэрээгээр гүйцэтгүүлж байгаа ажлын талаар та мэдэх үү?
2. Энэхүү дэд гэрээгээр гүйцэтгүүлж байгаа ажил нь ямар ажил болох, тэнд эмэгтэйчүүдийн хийх ажил, ажиллах нөхцөл ямар байгаа талаар мэдэх үү?

ГУРАВ.

УУРХАЙН ОЛБОРЛОЛТ ХААГДСАН БОЛОН ХАЯГДАЖ ОРХИГДСОН ҮЕД ХИЙХ ЖЕНДЭРИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Хуулийн эрх зүйн зохицуулалт

МУ-ын хуулиудад уул уурхайн хаалтын үед төр –компани, компани – иргэд, нийгмийн хооронд үүсэх харилцааг зохицуулсан хууль тогтоомж маш ховор. Мөн хаалт хийсэн уурхайн төсөл одоогоор байхгүй, зөвхөн үзүүлэх сургууль хэлбэрээр Налайхын уурхайд жишиг гаргаж байсан

Ашигт малтмалын тухай хууль	27.1.12.энэ хуулийн 48.6.1-д заасан тухайн ордыг ашиглах техник-эдийн засгийн үндэслэлдээ тухайн уурхайн бүтээгдэхүүнийг тээвэрлэх, дэд бүтцийг хэрхэн бүрдүүлэх болон уурхайн нөхөн сэргээлт, хаалт зэрэгт шаардагдах хөрөнгийн талаар тодорхой тусгасан байх;	АМГТГ-т байх техник эдийн засгийн үзүүлэлтийн баримт бичигт уурхайн нөөцийг олборлож дууссаны дараа тухайн талбай, кемпийг ямар зориулалтаар ашиглах, нүүлгэх, тэр орчимд химийн бодисын аюулгүй байдлыг хэрхэн хангах талаар тусгасан байх тул түүнтэй заавал танилцаж мэдээллийг ил тод нээлттэй болгох улмаар хэрэгжилтийг шаардаж хэрэгжүүлэх боломжтой
-----------------------------	---	---

I. Ерөнхий мэдээлэл

1. Байршил: (Улс, олборлолт хийх газар):
2. Уурхайн компанийн нэр?
3. Олборлолтын төрөл:
 - Нүүрс
 - Алт
 - Зэс
 - Бусад.....
4. Уул уурхайн төслийн санхүүжилт, хөрөнгө оруулалт нь хаанаас вэ?
 - Монгол
 - Орос
 - Хятад
 - Бусад.....
5. Асуулга авч буй огноо: 20. . оны . . сарын . . . өдөр
6. Компани хэзээнээс эхэлж олборлолт явуулж эхэлсэн бэ?
 - 20.. оны .. . –р сарын ... өдөр
7. Компани үйл ажиллагаагаа эхлүүлэх үедээ уурхай хаах төлөвлөгөөг танилцуулж байсан уу?
 - Тийм
 - Үгүй
 - Мэдэхгүй

8. Компани олборлоо (үйл ажиллагаагаа) хэзээ зогсоосон бэ?
 20. . оны . . сар Мэдэхгүй
9. Компани үйл ажиллагаагаа зогсоох талаар та хэзээ мэдсэн бэ?
 20. . оны . . сар Мэдэхгүй
10. Компани үйл ажиллагааг зогсоох талаар та хангалттай мэдээлэлтэй байж чадсан уу?
 Тийм Үгүй Мэдэхгүй

II. Уурхайн ажилчидтай холбоотой асуудлууд

1. Компани уурхайг хаасны дараа ажилтнууддаа зориулсан ямар нэг тусгай төлөвлөгөө гаргасан байсан уу?
 Тийм Үгүй Мэдэхгүй
2. Тус компанид ажиллаж байсан орон нутгийн эмэгтэйчүүдэд уурхай хаагдсанаар ямар нөлөө үзүүлсэн бэ?
 Эерэг нөлөө Сөрөг нөлөө Мэдэхгүй
3. Тэдний уурхайд ажиллаж байх үеийн болон одоогийн амьдралын чанарыг харьцуулбал ямар байгаа вэ?
 Амьдрал дээрдсэн Амьдрал дордсон Одоогоор мэдэхгүй байна
4. Компани уурхай хаах төлөвлөгөөгөө анх танилцуулж байсныхаа дагуу хэрэгжүүлж чадсан уу?
 Тийм Үгүй Мэдэхгүй

III. Бие мах бодь эрүүл мэндэд учруулах хор нөлөөлөл

Хаагдсан уурхайн ухсан нүх, химийн бодис, үлдэгдэл хог хаягдлаас болж орон нутгийн иргэдийн бие мах бодийн эрүүл мэндэд, ялангуяа эмэгтэйчүүдэд ямар нэг хор хөнөөл учирсан уу?

№	Хор хөнөөлийн төрлүүд	Хор хөнөөл үзүүлсэн	Хор хөнөөл үзүүлээгүй	Одоогоор мэдэхгүй байна
1.	Уурхайн хаягдал			
2.	Тэсрэмтгий бодис			
3.	Агаар хордсон/агаар бүтсэн			
4.	Цацраг идэвхт бодис			

5.	Хортой хог хаягдал			
6.	Унах аюултай шат, кран			
7.	Далд, аюултай шугам хоолойнууд			
8.	Нөхөн сэргээлт хийгээгүй орхисон талбай			
Дараах тохиолдлууд уурхай хаасны дараа гарсан уу?		Тийм	Үгүй	Мэдэхгүй
1.	Орхигдсон уурхайн газар нутагт амьдарч буй амьтдын тоо цөөрөх			
2.	Хүн, амьтан, мал уснаас хордох, усанд живэх			
3.	Хүн, амьтан, мал цахилгаанд цохиулж үхэх			
4.	Хүн, амьтан, малын дээрээс хад чулуу унах			
5.	Хаагдсан уурхайн хаягдал, төмрийн хаягдлаас үүдэн орон нутгийн иргэд, малын ундаалдаг усны урсгалд өөрчлөлт орсон уу?			
6.	Бусад			

IV. Байгаль орчны асуудлууд

№	Байгаль орчин	Хор хөнөөл үзүүлсэн	Хор хөнөөл үзүүлээгүй	Одоогоор мэдэхгүй байна
1.	Агаарт			
2.	Усанд			
3.	Хөрс, хөрсний элэгдэл, тариалангийн талбайд			
4.	Усан дахь бодис, биетүүдийн туналт			
5.	Ургамалд			
6.	Амьтад			

Компанийн зүгээс ямар нэг нөхөн сэргээх үйл ажиллагаа (хөрсийг дахин тэгшлэх, гадаргын хөрсийг сэргээх, мод, өвс тарьж ургуулах гэх мэт) хийсэн үү?

- Тийм Үгүй Мэдэхгүй

V. Бусад

1. Уурхай хаагдсанаас хойш уурхайн нөлөөллийг үнэлэх үнэлгээг компани хийсэн үү?
 Тийм Үгүй Мэдэхгүй
2. Хаагдсан уурхайн үр нөлөөний талаар илүү мэдлэгтэй болгох үүднээс засгийн газар, эсвэл иргэд ямар нэг сургалт, уулзалт хийсэн үү?

- Тийм Үгүй Мэдэхгүй
3. Ажилгүй болсноос, эсвэл байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлаас болж шилжин суурьшилт явагдсан уу?
- Тийм Үгүй Мэдэхгүй
4. Засгийн газрын зүгээс газар, орлогоо алдсан иргэдэд, мөн нийгэм, соёл, байгаль орчны доройтлоос болж хохирсон эмэгтэйчүүдэд нөхөн төлбөр олгосон уу?
- Тийм Үгүй Мэдэхгүй

Ганцаарчилсан болон бүлгийн ярилцлагын үеэр асуух асуултууд:

I. Уурхайн ажилчид болох хаалт

1. Тус компанид ажиллаж байсан орон нутгийн эмэгтэйчүүдэд уурхай хаагдсанаар ямар нөлөө үзүүлсэн бэ?
2. Компанид ажиллаж байсан ажилчид, уурхай хаагдсаны дараа хэрхэн амьжиргаагаа залгуулах орлого олж байна вэ?
3. Тэдний уурхайд ажиллаж байх үеийн болон одоогийн амьдралын чанарыг харьцуулбал ямар байгаа вэ?
4. Уурхайн хаагдсанаас болж ажилгүй болсон иргэдэд ямар нэг нөхөн олговор, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлсэн үү? Амлаж байсан нөхөн олговоруудаа бүрэн өгсөн үү?

II. Бие мах бодийн эрүүл мэндэд учруулах хор нөлөө

1. Хаагдсан уурхайн хаягдал, төмрийн хаягдлаас үүдэн орон нутгийн иргэдийн ундаалдаг усны урсгалд өөрчлөлт орсон уу?
2. Хаагдсан уурхайн газар нутагт ямар нэг аваар, осол гарсан уу? хэрэв тийм бол хохирогчдод ямар нэг нөхөн төлбөр өгсөн үү?
3. Уурхай хаагдсаны дараа усны хангамж, гэрэл цахилгаан, ус ариун цэвэр, сургууль, эмнэлэг гээд нийтийн үйлчилгээнд ямар нэг өөрчлөлт гарсан уу? эдгээр үйлчилгээнүүдээс хаагдсан зүйл байгаа юу? Хэрэв тийм бол энэ нь орон нутгийн иргэдэд хэрхэн нөлөөлсөн бэ?

III. Байгаль орчны асуудлууд

1. Байгаль орчинд ямар нэг нөлөө үзүүлсэн үү? Орон нутгийн иргэдэд ямар нөлөө үзүүлсэн бэ?
 - а. Агаар

- b. Ус
- c. Хөрс, хөрсний элэгдэл, тариалангийн талбай
- d. Усан дахь бодис, биетүүдийн туналт
- e. Ургамал
- f. Амьтад

2. Компанийн зүгээс нөхөн сэргээх ямар үйл ажиллагааг хийсэн бэ? (хөрсийг дахин тэгшлэх, гадаргын хөрсийг сэргээх, мод, өвс тарьж ургуулах гэх мэт)

IV. Эрүүл мэндийн асуудлууд

1. Компани уурхайг хаасны дараа, уурхайн олборлолтоос үүдэлтэй эмэгтэйчүүдийн эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлсэн бэ?
2. Мөн гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндэд ямар нөлөө үзүүлсэн тэр хэрхэн илэрч байна вэ?
3. Орон нутгийн иргэд болон уурхайд ажиллаж байсан ажилчид эрүүл мэндийн байдал муу байснаасаа болж нас барсан тохиолдол бий юу?
4. Эрүүл мэндтэй холбоотой гарсан асуудлыг шийдвэрлэхэд компани, засгийн газраас ямар арга хэмжээ авсан бэ? Тэд ямар нэг нөхөн төлбөр өгсөн үү?

V. Бусад

1. Хаагдсан болон хаягдсан уурхайд хууль бус олборлогчид ажиллаж байгаа юу?
2. Дээр дурдсан бие махбод, эрүүл мэндийн, байгаль орчны, нийгэмд гарсан сөрөг нөлөөг буруулахад ямар арга хэмжээ авсан бэ? Энэ үйл ажиллагаанд орон нутгийн иргэд хэрхэн оролцсон бэ?
3. Уурхай хаагдсаны дараа иргэдэд тулгарсан асуудлыг шийдвэрлэхэд засгийн газар юу хийсэн бэ?
4. Компани болон засгийн газрын төлөөллөөс иргэдтэй уулзсан уу? хэрэв тийм бол тэдний хариу авсан арга хэмжээ нь юу байсан бэ?
5. Нутгийн захиргааны засаглалд ямар нөлөөлөл үзүүлсэн гэж та үздэг вэ? Сайнаар бол ямархэрэв сөрөг нөлөө үзүүлсэн гэж үзэж байгаа бол ямар
6. Таны нэмж хэлэхийг хүссэн бусад асуудлууд

ЖҮНҮ-ний үр дүнг нэгтгэн боловсруулж, нөлөөлөлд ашиглахад бэлтгэх

Дараах хүснэгтийг загвар болгон ашиглаж уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрх, эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийг баримтжуулж, зөрчигдсөн эрхээ сэргээн хамгаалж, хүний эрх зөрчигдөхөөс хамгаалаарай.

№	Эрхийн зөрчлүүд	Үнэлгээний аргачлал, шаардлагатай баримтжуулалтууд
1.	Эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй холбоотой зөрчлүүд	<ul style="list-style-type: none"> • Орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдээс авах асуулга, ярилцлага • Эрүүл мэндийн эрхийн зөрчилтэй холбоотой зураг, ажиглалтын тайлан • Уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэлтэй тухайн орон нутгийн иргэдийн эрүүл мэндийн асуудалд гарсан өөрчлөлтийн талаарх сумын эмнэлгийн судалгаа, тайлан, нэгтгэл • Сумын эмнэлгийн эмчтэй хийсэн ярилцлага • Эрүүл мэндийн хохирол учирсныг батлах эмнэлгийн шинжилгээ, бусад холбогдох бичиг баримтууд
2.	Эмэгтэйчүүдийн эрх, жендэртэй холбоотой зөрчлүүд	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн хайгуулын болон ашиглалтын лизенз олгох үйл явцад эмэгтэйчүүдийг оролцуулсан эсэхийг үнэлэхэд туслах асуулга, ярилцлагууд • Уул уурхайгаас үүдэлтэй эмэгтэйчүүд өөрийн өмчилж байсан газраа алдсан эсэх, булаалгасан, хөөгдсөн эсэхийг үнэлэх зорилготой асуулга, ярилцлагууд • Уурхай эхэлсэнтэй холбоотойгоор малын сүү, сүүн бүтээгдэхүүн болон малын махнаас олдог байсан орлого хэрхэн буурсан талаарх асуулга, ярилцлага • Уурхайн компанид ажиллаж буй эмэгтэйчүүдэд тэгш оролцоо, тэгш боломж байгаа эсэх талаарх асуулга, ярилцлага болон уурхайн компанийн холбогдох хүний нөөцийн бодлогуудад дүн шинжилгээ хийх • Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тухайн уурхайн бүс нутгийн эмэгтэйчүүдийн гэрийн ажил болон мал маллахад нь гарсан сөрөг нөлөөллүүдийг үнэлэх зорилго бүхий асуулга, ярилцлагууд • Уурхайн үйл ажиллагаатай холбоотой гэр бүлийн хүчирхийлэл, хүчин, болон биеэ үнэлэлт, БЗДХалдвар ихэссэн талаарх ярилцлага, асуулга, уурхайн болон сумын эмч нарын хийсэн статистик мэдээлэл, тайлан, эсвэл ярилцлага
3	Нийгэм, соёлын эрхийн зөрчлүүд	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор тухайн орон нутагт гарч байгаа, үүсээд байгаа нийгмийн шинжтэй асуудлуудыг үнэлэх зорилго бүхий асуулга, ярилцлага • Уул уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотойгоор тухайн орон нутагт гарч буй архидалт, зодоон танхай, хүчин, хулгай зэрэг гэмт хэргийн төрөл, давтамжийн талаарх орон нутгийн цагдаагийн байгууллагын гаргасан мэдээ, тайлан, баримтын уурхай эхлэхийн өмнөх үетэй харьцуулан харьцуулалт • Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотойгоор гэр бүлийн хүчирхийлэл, БЗДХ-ын тоо, амиа хорлолт, нутаг усаа булаацалдсанаас үүссэн маргаан зөрчилдөөний тоо, давтамжийн талаарх орон нутгийн цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн бүртгэл

		<ul style="list-style-type: none"> • Уур уурхайн олборлолтоос бол өвөлжөө, болон өөрийн өмчийн газраа булаалгасан өрхийн тоо, өвс тэжээл хадлангаа авч чадахгүй хавчигдаж байгаа нутгийн иргэдийн тоо, сүслэн биширдэг уул усандаа очих боломжгүй болсон, эсвэл өвөг дээдсийн үеэс шүтэж ирсэн ариун дагшин газраа уурхайн компанид булаалгасан, тэнд зорчих эрхээ хязгаарлуулсан нутгийн иргэдийн тоо, нийгмийн зураглал, дрон камерын тусламжтай авсан фото зураг болон видео бичлэг (хэрэв боломжтой бол) • Тухайн уул уурхайн олборлолт явуулж буй бүс нутагт амьдарч буй иргэдийн орлого буурсан талаарх судалгаа
4.	Байгаль орчин, болон амьдрах орчинг доройтуулж буй зөрчлүүд	<ul style="list-style-type: none"> • Уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй бүс нутагт амьдарч буй орон нутгийн иргэд, эмэгтэйчүүдээс байгаль орчин болон тэдний амьдрах орчны доройтолтой холбоотой авсан асуулга, ярилцлага • Ус, хөрс, агаар бохирдсон талаарх мэргэжлийн байгууллагын үнэлгээ, гаргасан дүгнэлтээр үнэлгээгээ баяжуулах • Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой ой мод багассан, ховор эмийн ургамал болон ан амьтан, шувууд устаж үгүй болсон талаарх байгаль хамгаалагч эсвэл экологийн цагдаагийн тэмдэглэл, мэдээлэл

ЖҮНҮ ашиглан эмэгтэйчүүд болон орон нутгийн иргэдийн эрхийг хамгаалсан амжилттай түүх

Завхан аймагт эмэгтэйчүүдийн эрхийн чиглэлээр ажилладаг “Өрнөх Хөгжил” ТББ 2018 онд ЖҮНҮ-г тус аймгийн Ургамал суманд олборлолт явуулж байсан Форс Гоулд Майнинг ХХК-ийн нөлөөллийн бүс-д хийжээ. Үнэлгээ хийх явцад тухайн орон нутгийн дийлэнх эмэгтэйчүүд тус компани олборлолт явуулж эхэлснээс хойш усны хомсдол ихээр үүсч байгааг асуулга болон ярилцлагын үеэр судалгаанд оролцогчдын 85%²² илэрхийлсэн байна. Тиймээс “Өрнөх Хөгжил” ТББ-ын үнэлгээний баг нь орон нутгийн эмэгтэйчүүдэд усны хомсдолоос үүдэлтэй эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөлөл хэрхэн гарч байгааг лавшруулан судалж, баримтжуулсны үндсэн дээр Ургамал сумын орон нутгийн холбогдох байгууллагуудаас тус компанигай байгуулсан усны гэрээ, байгаль орчны үнэлгээний тайлангуудыг цуглуулан авч дүн шинжилгээ хийжээ. Ингээд олж авсан мэдээлэл дээрээ үндэслэн тухайн орон нутгийн удирдлагуудад хяналт шалгалт явуулах нөлөөллийн ажил явуулсны үр дүнд Ургамал сумын Тамгын газраас Хяргас нуур сав газрын захиргаатай хамтран 2018-10-30 нд хийсэн дотоодын хяналтаар Форс Гоулд Майнинг ХХК нь усны цооногийг газар доогуур ус дамжуулах шугам хоолойтой холбож хулгайгаар ус ашиглаж байсан нь тогтоогдож, 2018-11-02 ны өдөр сумын Засаг дарга ус ашиглуулах гэрээгээ цуцалсан байна.

²² Өрнөх Хөгжил ТББ-ын ЖҮНҮ судалгааны тайлан, 2018 он

Мөн ЖҮНҮ-ний үр дүнг ашиглан орон нутгийнхаа холбогдох мэргэжлийн байгууллагад хандсанаар Аймгийн МХГ-аас Форс Гоулд Майнинг ХХК-ны уул уурхайн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийлгүүлжээ. Энэ шалгалтаар тус компани ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайгаас давж нийтийн эдэлбэрийн газарт олборлолт явуулсан, малчдын малаа усалдаг Ханын өрөмдмөл худгийн барилга байгууламжийг зөвшөөрөлгүй нурааж, худгийн насос байрлах гүнийг өөрчилсөн зэрэг ноцтой зөрчил дутагдлууд байгааг олж илрүүлсэн. Энэ нь ЖҮНҮ-гээр илэрсэн зөрчил дутагдлыг баримтжуулан албажуулж нотолгоо гаргуулсан бодит жишээ юм. Энэхүү нотолгоог ашиглан шүүхэд гомдол гаргасны үндсэн дээр шүүхээс Форс Гоулд Майнинг ХХК үйл ажиллагааг 2018 онд зогсоох шийдвэр гаргаж, илүү ашигласан усны төлбөрийг төлүүлэхээр болсон байна.

ДҮГНЭЛТ

ЖҮНҮ бол уул уурхайн олборлолт явуулснаар байгаль орчинд, түүний бүрэлдэхүүн хэсгүүдэд гарч буй өөрчлөлт, доройтол нь тухайн төслийн нөлөөллийн бүсэд амьдарч буй эмэгтэйчүүдийн ямар төрлийн эрх, эрхэм чанарыг хэрхэн зөрчиж байгааг үнэлдэг. Харин ЖҮНҮ-ний дүгнэлтийг гаргахдаа байгаль орчны зөрчил болон эмэгтэйчүүдийн эрхийн зөрчлийн харилцан хамаарлыг дүгнэж, хүний эрхийн зөрчил төдийгүй байгаль орчны зөрчлийг хамтад нь баримт нотолгоотой үнэлж дүгнэлт гаргана.

ЖҮНҮ тусламжтайгаар цуглуулсан мэдээллээ ашиглан, хүний эрхийн зөрчил, байгаль орчны бохирдол, эрүүл мэндийн хохирлыг өөрсдөө болон холбогдох мэргэжлийн байгууллагуудын тусламжтайгаар нотлох, баримтжуулах замаар хуулиар хамгаалагдсан эрхээ төр болон бизнес эрхлэгчдээр хангуулах, зөрчигдсөн эрхээ сэргээлгэх бүрэн боломжтой болох юм.

Товчдоо, экологийн доройтол нь хүний эрхийн тэр дундаа эмэгтэйчүүдийн эрхийн зөрчил үүсгэх төдийгүй тэдний ирээдүйг үгүй хийх аюултай гэдгийг талуудад бодит баримтаар харуулах хэрэгсэл нь ЖҮНҮ юм. Иймд ЖҮНҮ аргачлалыг бүтээлчээр ашиглах, түгээн дэлгэрүүлэх, улам боловсронгуй болгож уул уурхайн салбарын засаглалыг сайжруулах, хүний эрхэд суурилсан жендэрийн мэдрэмжтэй, охид эмэгтэйчүүдэд ээлтэй салбар болгох улмаар МУ-ын тогтвортой хөгжлийг түргэтгэхэд, хүний эрхийн хамгаалагчид энэхүү аргачлалыг тууштай ашиглах нь жинтэй хувь нэмэр оруулах ач холбогдолтой.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ:

1. Ашигт малтмалын тухай хууль, (2006)
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (2012)
3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29 –ний өдрийн А/618 тоот тушаалын хавсралт: БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ, ХЯНАН БАТЛАХ, ТАЙЛАГНАХ ЖУРАМ
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, (2011)
5. Иргэний Шийдэл Бодлогын Судалгааны Хүрээлэнгээс Австралийн Күинсландын Их Сургуулийн Тогтвортой Эрдэс Баялгийн Хүрээлэн, “Хариуцлагатай уул уурхай сургалтын гарын авлага”, (2016)
6. МОНЭС & Хил Хязгааргүй Алхам ТББ, “Уул уурхай ба Иргэдийн оролцоо” гарын авлага, (2020)
7. Оксфордын тайлбар толь бичиг
8. Өрнөх Хөгжил ТББ-ын ЖҮНҮ судалгааны тайлан, 2018 он
9. Усны тухай хууль, 3-р Зүйл (2012)
10. Уул уурхайн үйл ажиллагаанд хяналт тавих, байгаль орчин хүний эрхийг хамгаалах хүсэл эрмэлзэлтэй эмэгтэйчүүдэд зориулсан гарын авлага, Уул уурхайн үйл ажиллагаан дахь Азийн эмэгтэйчүүдийн хөдөлгөөн, (2020)
11. <https://eic.mn/>
12. WAMA, “Resource guide for monitoring extractives” handbook (2019)
13. www.e-reporting.eitimongolia.mn
14. https://www.ot.mn/media/ot/content/esia-audits/OT_ESIA_Audit_report_Nov_2014_MN.pdf - Байгаль орчин, Нийгмийн хөндлөнгийн зөвлөхийн тайлан, Оюу Толгой төсөл (2014)